



ЗҮҮН БҮС БОЛОН НИЙСЛЭЛИЙН ХЭМЖЭЭНД 2022 ОНД ХИЙГДСЭН СООЛЫН БИЕТ БҮС ӨВИЙН ҮЗЛЭГ, СУДАЛГААНЫ АЖЛЫН НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Тайлан бичсэн: А.Саруул, Соёлын өвийн үндэсний төвийн Бүртгэл, мэдээллийн газрын дарга

Хянасан: Г.Энхбат, Соёлын өвийн үндэсний төвийн захирал

Улаанбаатар хот

2022 он

АГУУЛГА

НЭГ. ЗҮҮН БҮС БОЛОН НИЙСЛЭЛИЙН СББӨ-ИЙН УЛСЫН ҮЗЛЭГ, СУДАЛГААНЫ ТОЙМ

1.1. Зүүн бүс болон нийслэлийн СББӨ-ийн улсын үзлэг, судалгааны үр дүн (зорилго, зорилтын биелэлт)

1.2. СББӨ-д хийсэн цахим судалгааны тоон болон аналитик үзүүлэлт

1.3. СББӨ-ийн ай, өвийн төрлүүдэд хийсэн судалгаа

ХОЁР. ЗҮҮН БҮС БОЛОН НИЙСЛЭЛИЙН СББӨ-ИЙН УЛСЫН ҮЗЛЭГ, СУДАЛГААНЫ НЭГДСЭН ДҮГНЭЛТ

2.1. Зүүн бүс болон нийслэлийн СББӨ-ийн улсын үзлэг, судалгааны дүгнэлт

2.2. Нэгдсэн дүгнэлт

2.3. Зөвлөмж, санал

НЭГ. ЗҮҮН БҮС БОЛОН НИЙСЛЭЛИЙН СББӨ-ИЙН УЛСЫН ҮЗЛЭГ, СУДАЛГААНЫ ТОЙМ

1.1. Зүүн бүс болон нийслэлийн СББӨ-ийн улсын үзлэг, судалгааны үр дүн (зорилго, зорилтын биелэлт)

Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 13.1.6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт “Соёлын биет бус өвийн үзлэг хийх журам”, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/235 тушаал, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын даргын 2022 оны А/42 тушаалыг үндэслэн Соёлын биет бус өвийн үзлэг, бүсчилсэн судалгааг Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймаг, Нийслэлийн 9 дүүрэг буюу нийт 4 бүсэд тус бүр 4-5 хүний бүрэлдэхүүнтэй судалгааны баг 2022 оны 9 дүгээр сараас 11 дүгээр сар хүртэл 45 хоногийн хугацаатай ажиллав. Үүнд: Дорнод аймгийн судалгааны багийн ахлагчаар Бурхан Халдундэлхийн өвийн захиргааны газрын эрдэм шинжилгээний ажилтан А.Дүүрэнжаргал, Сүхбаатар аймгийн судалгааны багийн ахлагчаар Нүүдлийн Соёл Иргэншлийг судлах олон улсын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Ц.Баяртогтох, Хэнтий аймгийн судалгааны багийн ахлагчаар Шинжлэх Ухааны Академийн Хэл зохиолын хүрээлэнгийн Аман зохиол судлах салбарын эрхлэгч доктор А.Алимаа, Нийслэлийн судалгааны багийн ахлагчаар Соёлын өвийн үндэсний төвийн бүртгэл, мэдээллийн газрын Бүртгэл мэдээллийн санч Т. Оюунбат нар тус тус томилогдон ажиллав.

1.1.1	СББӨ-ийн уламжилсан байдал, шилжилт хөдөлгөөн, нийгэм, эдийн засаг, эрүүл мэндийн нөхцөл байдлын судалгаа хийх;	<p>СББӨ-ийн улсын үзлэг, судалгаагаар Сүхбаатар аймгийн 11 сум, Хэнтийн аймгийн 16 сум, 3 тосгон, Дорнод аймгийн 14 сум, Нийслэлийн 9 дүүрэгт тус тус ажиллав.</p> <p>СББӨ-ийн 400 өвлөн уламжлагчаас цаасан хэлбэрээр судалгааг авч, судалгаанд хамрагдсан нийт 335 өвлөн уламжлагчийн мэдээллийг цахим бүртгэлд (google form) шивж оруулав. Үүнд: Дорнод - 78, Сүхбаатар - 79, Хэнтий - 78, Улаанбаатар 100 өвлөн уламжлагч байна. Судалгааны явцад Дорнод– 33, Сүхбаатар – 4, Хэнтий - 28, буюу нийт 65 өвлөн уламжлагчийг шинээр бүртгэж, эдгээр өвлөн уламжлагчийн мэдээлэл нь цахим бүртгэлд (google form)-д ороогүй болно.</p> <ul style="list-style-type: none"> - Судалгаанд хамрагдсан 335 өвлөн уламжлагчийн СББӨ-ийг уламжилсан байдлыг авч үзвэл 3 ба түүнээс дээш үеэс өвлөсөн 113, 1-2 дахь үеэс өвлөсөн 230 хүн тус тус хамрагдсан байна. /аймаг тус бүрийн дэлгэрэнгүйг тайланд тусгасан болно. Зураг - 8/ - Шилжилт хөдөлгөөний асуулгад нийт 334 хамрагдсанаас аймаг доторх буюу сум хоорондын шилжилт хөдөлгөөн хамгийн их буюу 143 хүн тухайн сумын уулгуул биш гэсэн хариултыг бөглөсөн байна. /аймаг, дүүрэг тус
-------	---	--

		<p>бүрийн дэлгэрэнгүйг тайланд тусгасан болно. Хүснэгт -1/</p> <ul style="list-style-type: none"> - Тухайн өвлөн уламжлагчийн өвлөсөн өв өрхийн эдийн засаг, санхүүд хэрхэн нөлөөлдөг талаарх асуулгад 343 хүн хариулт илгээснээс “нөлөөлдөггүй” гэж 163 хүн хариулсан байна. /аймаг, дүүрэг тус бүрийн дэлгэрэнгүйг тайланд тусгасан болно. Хүснэгт -13/ - Эрүүл мэндийн нөхцөл байдлын хувьд нийт 44 хүн хариулт илгээснээс тулгуур эрхтэн, хөдөлгөөний 14, харааны 12, сонсгол, хэл ярианы 7, эпилепси 2, хавсарсан 1, бусад 8 буюу нийт 44 хүнд тусгай хэрэгцээт үйлчилгээ шаардлагатай байгааг харж болно. /аймаг, дүүрэг тус бүрийн дэлгэрэнгүйг тайланд тусгасан болно. Зураг-18/
1.1.2	<p>Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Бүртгэл шинэчлэн батлах тухай” 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/759 дүгээр тушаалаар баталсан Соёлын биет бус өвийн Төлөөллийн үндэсний бүртгэл, Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэлд бүртгэгдсэн өв, өвлөн уламжлагчийн талаар түүвэр судалгаа хийх;</p>	<p>Соёлын биет бус өв, түүнийг өвлөн уламжлагчийн Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд Дорнод 384, Сүхбаатар 443, Хэнтий 763, Улаанбаатар 1528 нийт 3118 өвлөн уламжлагч бүртгэлтэйгээс Дорнод-78, Сүхбаатар-79, Хэнтий-78, Улаанбаатар -100 буюу нийт 335 өвлөн уламжлагчийг түүвэр судалгаанд хамруулав.</p> <p>Түүвэр судалгаанд хамрагдсан өвлөн уламжлагчаас Соёлын биет бус өвийн үндэсний Төлөөллийн бүртгэлд бүртгэгдсэн нийт 279 өвөөс 7 ай савд хамаарах 173, Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн бүртгэлд бүртгэгдсэн 83 өвөөс 7 ай савд хамаарах 24 өв буюу нийт 197 төрөл зүйлийг тус тус хамруулсан байна.</p> <p>/аймаг, дүүрэг тус бүрийн дэлгэрэнгүйг тайланд тусгасан болно./</p>
1.1.3	<p>Тухайн орон нутагт оршин буй үндэстэн, угсаатны бүлэг, СББӨ-ийн төрөл зүйлийг таньж тогтоох, сурвалжлан олох;</p>	<p>-Судалгаанд хамрагдсан Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Нийслэлийн бүсийн нийт 335 өвлөн уламжлагч хамрагдсанаас Халх 227, Барга 9, Баяд 1, Буриад 38, Дархад 1, Дарьганга 34, Дөрвөд 3, Урианхай 2, Захчин 3, Торгууд 2, Хотон 1, Үзэмчин 9, Казак 1, Тува 1, Бусад гэсэн төрөлд 4 буюу нийт 14 угсаатны бүлэгт хамаарах өвлөн уламжлагчид байна. /Зураг- 2/</p> <p>-СББӨ-ийн өвлөн уламжлагч 65 хүнийг шинээр таньж тогтоосон. Эдгээр таньж тогтоосон 65 өвлөн уламжлагчийн өв нь СББӨ-ийн 7 ай савд хамаарах 28 өвийн төрөлд хамаарч байна.</p> <p>-Бүс нутгийн захиргааны нэгж хариуцсан мэргэжилтнүүд СББӨ-ийн тухай мэдлэг, ойлголт хангалтгүйн улмаас өвлөн уламжлагчид бүртгэгдээгүй гээгдэх хандлага ажиглагдав.</p> <p>Шинээр олж тогтоосон өв</p>

		<ul style="list-style-type: none"> - Хэнтий аймагт жоншны уурхайтай учраас жоншоор бэлэг дурсгал, хөөрөг урладаг өвлөн уламжлагч 2 хүн, мөн Казак түмний амьдрах, аж төрөх ёс, уламжлалт идээ, ундаа бэлтгэх зан үйл, мэдлэг арга ухааныг өвлөсөн өвлөн уламжлагч 2 хүнийг олж тогтоосон бөгөөд энэ өвийн төрөл нь Монгол Улсын Төлөөлөл үндэсний бүртгэл болон Яаралтай хамгаалах шаардлагатай СББӨ-ийн үндэсний бүртгэлд ороогүй өв юм.
1.1.4	<p>Соёлын биет бус өв, өв тус бүрийн хадгалалт хамгаалалтын өнөөгийн нөхцөл байдал, зэрэг болон сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг илрүүлж тогтоох, дүн шинжилгээ хийх;</p>	<p>-СББӨ-ийн хадгалалт хамгаалалтын өнөөгийн нөхцөл байдал, зэрэг болон сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг олж тогтоох, хүчин зүйлийг илрүүлэхэд судалгаанд ирүүлсэн хариулт болон өвийн өнөөгийн хадгалалт хамгаалалтын нөхцөл байдал зэргийг харьцуулж дүн шинжилгээг хийв.</p> <p><u>Зэрэг хүчин зүйл</u></p> <ul style="list-style-type: none"> - Техник, технологийн хөгжил, улмаар Ковидын хязгаарлалтаас үүдэн цахимаар дамжуулан СББӨ-өөс суралцах, таньж мэдэх, түгээн дэлгэрүүлэх боломж бий болсон. -Уламжлалт болгон зохион байгуулагддаг бүс, нутгийн олон улсын чанартай наадам, фестиваль, томоохон арга хэмжээ нь СББӨ-ийг бүс нутагт таниулах, өвийн үнэлэмжийг дээшлүүлэхэд эергээр нөлөөлдөг. -СББӨ-ийн үзлэгээр хийгдэж буй таньж тогтоох, судлах, бүртгэх, гэрэл, зураг дүрс бичлэгийн баримтжуулалт хийж байгаатай орон нутгийн шинэ ажилтан, мэргэжилтэн төдийгүй өвлөн уламжлагч танилцаж түүнээс суралцах таатай боломж, давуу тал болж байсан. <p><u>Сөрөг хүчин зүйл</u></p> <ul style="list-style-type: none"> - Шилжилт хөдөлгөөн нь нийгэм эдийн засгийн харилцаа, техник, технологийн хөгжил дэвшил, өөр орны соёлын урсгал зэрэг хөндлөнгийн хүчин зүйлээс шалтгаалан СББӨ хувьсан өөрчлөгдөх, эх төрхөө алдах, мартагдах, өвлөн уламжлагч бэлтгэгдэхгүй байх сөрөг нөлөө байгааг судалгаанаас харж болно. - Соёлын нийлэгжилт явагдаж СББӨ-ийн илэрхийлэлд ашиглагдах технологи шинэчлэгдэх, амарчлах, хялбаршуулах хандлага үүссэн. - Хотжилт, суурьшлаас хамааран “Байгаль сав шим, ертөнцийн тухай мэдлэг” ай савд хамаарах өвүүдийн соёлын орон зай бүдгэрч, хэрэгцээ багассан. - Малын бэлчээрийн хомсдол, уул уурхай дагасан байгаль орчинд учирч буй хор хөнөөл нь малчин айл, өрхийн нүүдэллэх, тогтвор суурьшилтай амьдрах зэрэгт сөргөөр нөлөөлж байна. <p>/Зураг 22,23/</p>

		- Дүүргийн ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтсийн соёл, хариуцсан мэргэжилтэн, хорооны хөгжлийн нийгмийн ажилтан нарын хоорондын хамтын ажиллагаа, СББӨ-ийн талаарх мэдлэг ойлголт дутмаг байгаагаас нь өв, өвлөн уламжлагчийг гээгдүүлэх, харилцах, хамтын ажиллагаанд сөргөөр нөлөөлж байгааг судалгааны явцад ажиглагдав.
1.1.5	СББӨ болон өвлөн уламжлагчийн тоо, газарзүйн тархалтыг тогтоох;	Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Нийслэлийн 9 дүүргийн СББӨ-ийн УНБМСанд бүртгэлтэй бүртгэгдсэн 3118 өвлөн уламжлагчаас 335 өвлөн уламжлагчийг түүвэрлэн судалгаанд хамруулан угсаатны бүлэг болон өвийн газарзүйн тархалтыг сум, баг, хороо бүрээр тус тус тогтоосон. Тархалтын зураглалд, Сүхбаатар аймаг СББӨ-ийн Төлөөллийн үндэсний бүртгэлд хамаарах 40 өвийн 68 өвлөн уламжлагч, Яаралтай хамгаалах шаардлагатай СББӨ-ийн үндэсний бүртгэлд хамаарах 3 өвийн 4 өвлөн уламжлагч, ЮНЕСКО-гийн Хүн төрөлхтний СББӨ-ийн бүртгэлд хамаарах 2 өвийн 7 өвлөн уламжлагч, Дорнод аймаг СББӨ-ийн Төлөөллийн үндэсний бүртгэлд хамаарах 50 өвийн 75 өвлөн уламжлагч, Яаралтай хамгаалах шаардлагатай СББӨ-ийн үндэсний бүртгэлд хамаарах 2 өвийн 2 өвлөн уламжлагч, ЮНЕСКО-гийн Хүн төрөлхтний СББӨ-ийн бүртгэлд хамаарах 4 өвийн 4 өвлөн уламжлагч, Хэнтий аймаг СББӨ-ийн Төлөөллийн үндэсний бүртгэлд хамаарах 22 өвийн 73 өвлөн уламжлагч, Яаралтай хамгаалах шаардлагатай СББӨ-ийн үндэсний бүртгэлд хамаарах 5 өвийн 6 өвлөн уламжлагч, ЮНЕСКО-гийн Хүн төрөлхтний СББӨ-ийн бүртгэлд хамаарах 3 өвийн 8 өвлөн уламжлагч, Нийслэлийн СББӨ-ийн Төлөөллийн үндэсний бүртгэлд хамаарах 33 өвийн 82 өвлөн уламжлагч, Яаралтай хамгаалах шаардлагатай СББӨ-ийн үндэсний бүртгэлд хамаарах 7 өвийн 7 өвлөн уламжлагч, ЮНЕСКО-гийн хүн төрөлхтний СББӨ-ийн бүртгэлд хамаарах 3 өвийн 11 өвлөн уламжлагч хамрагдлаа. <i>Зураг 28 /нийт 335 өвлөн уламжлагч хамрагдсан/</i>
1.1.6	Тухайн орон нутагт СББӨ-ийн чиглэлээр зохион байгуулагдсан арга хэмжээний мэдээллийг цуглуулах;	Сүхбаатар аймаг: “СББӨ урлагийн бага наадам” 13 сумын 400 өвлөн уламжлагч орсон, “Нүүдэлчин монгол” өв соёлын их наадам 61 өвлөн уламжлагч орсон, “Хунгийн баяр” Дарьганга 6 сумын ардын авьяастнуудын тоглолт, гар урлалын үзэсгэлэн “Агтана хүрээт монгол адууны өв соёл”-ын наадам, “Үзэмчин Дарьганга өв соёл”-ын үзэсгэлэн Дорнод аймаг:

		<p>“Алтаргана” Буриадын угсаатны бүлгийн Олон Улсын наадам “Алтан дөрөө Үзэмчин угсаатны бүлгийн”, “Баргажин”, Барга угсаатны хувьд “Хатиган” зэрэг соёлын наадмууд</p> <p><u>Хэнтий аймаг:</u> “Бага Алтаргана” наадам “Хэрлэнгийн барьяа” наадам “Талын түмэн адуу” наадам</p> <p><u>Нийслэл хот:</u> “Дээлтэй Монгол” “Нүүдэлчин Монгол” наадам Нийслэл хотын төрийн ба төрийн бус байгууллагуудыг хамруулдаг. “Урлагийн наадам” дүүргүүдийн хооронд Соёлын орон зайг хамтдаа бүтээе” арга хэмжээ “Соёлын бүтээлч сар” аяны хүрээнд зохиогдсон үйл ажиллагаанууд уламжлал болон зохион байгуулагдсаар байна.</p>
1.1.7	СББӨ-ийн үзлэг, судалгааны үр дүнгийн талаарх урьдчилсан дүгнэлт гаргах;	<p>Тайлан тус бүрд судалгааны багийн судлаач нар урьдчилсан дүгнэлт гаргасан. Үүнд: Тухайлбал:</p> <p><u>Хэнтий аймаг:</u> <u>Өвийн тухай</u> Хэнтий аймагт СББӨ-ийн 7 айн 56 төрлийг бүртгэн баримтжуулсан бөгөөд гар урлалын ай давамгайлж байна. Энэ аймгийн СББӨ-ийн онцлог морины соёл, түүнийг дагалдсан морь шинжих, уях сойх, суран эдлэл хөгжих болжээ. Сүүлийн үед шагайн харваа, хавчаахай нумыг өндөр настнууд бүлэг болон харвах болсон, мөн тайга нохойн соёл дэлгэрч, залуус ихэд сонирхож байгаа нь ажиглагдлаа. Гар урлалын зүйлээс үндэсний дээл хувцас, малгайн урлал голлож байгаа нь өвлөгчдийн хүйстэй холбоотой байж болно. Харин чулуу, модон сийлбэр цөөн боловч чанартай өв байх бөгөөд байгалийн нөөц баялагт тулгуурлажээ. Бэрх, Бор-Өндөрт жоншны уурхайтай учраас жонш чулуугаар бэлэг дурсгалын зүйл урладаг 2 өвлөгчтэй тааралдав. Эх хэл, аман уламжлал, илэрхийллийн айд халх туулийн голомт ховор боловч байгааг нь олж тодруулсан нь судалгааны багийн олз гэж хэлж болно. Харин бусад төрөл мартагдах шинжтэй болсныг зориуд тэмдэглэж байна. Тиймээс аман соёлын өвийг түлхүү анхаарч язгуур урлагтай холилдуулалгүй хөгжүүлэх шаардлага тулгарчээ. Мөн хамниган аялгуу үндсэндээ мөхөж байгааг анхаарч яаралтай баримтжуулалт хийх, толь бичиг болтугай авч үлдэх ёстой болжээ. Өв өвлөн уламжлагдах байдлыг судалгаанаас харахад 1 дэх үедээ өвлөн уламжлагчид олон бол 3</p>

дахь үедээ өвлөн уламжлагчид хамгийн цөөн буюу 13 хувьтай байгаад бид анхаарлаа хандуулах шаардлагатайг харуулж байна.

Өв өвлөн уламжлагдах байдлын хувьд ахуй амьдралаасаа сурч мэдсэн нь 73,8%, албан бус сургалтаар 6,2% байгаа нь Хэнтий нутгийн өв харьцангуй язгуур чанараа алдаагүй байгаа хэрэг юм. Энэ нь өвлөн уламжилсан хэлбэрүүдийн үзүүлэлтээр баталгаажиж байгаа бөгөөд өвлөн уламжлагчийн 55% нь гэр бүл, 11% нь төрөл садангаасаа сурчээ. Тиймээс соёлын өвийг уламжлан хадгалах цаашдын хандлагыг энэ чиглэлд илүү анхаарах нь зүйтэй.

Өвлөн уламжлагчдын тухайд

Хэнтий аймгийн 16 сум, 3 тосгонд ажиллаж нийт 106 өвлөн уламжлагчтай уулзаж бүртгэлтэй 79 хүнийг цахим бүртгэлд хамруулсан. Мөн Биндэр, Батширээт, Баянхутаг суманд хамниган аялгуу, өвийн талаар мэддэг настайчуудыг сураглаж 4 хүнтэй уулзсан бөгөөд бүртгэлд хамрагдаагүй энэ мэт хүмүүс байв.

Нийт өвлөн уламжлагчийн хүйсийн байдал эмэгтэй давамгай буюу 51%, насны хувьд тэтгэврийн хүмүүс (79 хүний 37 нь) эзэлж байна. Магадгүй бид настайчуудтай эхэлж уулзах гэдэг сонирхол давамгай байж болох ч ерөнхийдөө өвлөн уламжлагчид буюу уламжлалаа мэддэг, өвийн зүйлээ хадгалж хийж байгаа хүмүүс бол өндөр насны тэтгэвэртээ гарсан, эмэгтэйчүүд голлож байсан. Тэдний идэвх оролцоо ч сайн, Соёлын төвөөс зохиодог аливаа соёл, урлагийн арга хэмжээнд голлон идэвх санаачилгатай оролцдог болохыг соёлын байгууллагын ажилтнууд дурдаж байсан.

СББӨ-ийн бүртгэн баримтжуулалтын тухай

УНБМСанд анхан шатны бүртгэлээр бүртгэгдсэн өвлөн уламжлагчийн шалгуурыг хангаагүй болон өөрийн хүсэлтээр бүртгэлээс хасалт хийлгэх саналыг үзлэгийн багт уламжилж байсан. Мөн бүртгэлийн мэдээлэлд шилжилт хөдөлгөөний тэмдэглэлийг цаг тухайд нь хийгээгүйн улмаас тоон дүн зөрөх, давхардах зэрэг бүртгэлийн нийтлэг алдаа гарсаар байна. Үзлэгээр 28 өвлөн уламжлагчийг шинээр тодруулав.

СББӨ-ийн дэмжлэгийн тухай

Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт СББӨ-ийн талаар 3-4 зүйл тусгагдсан ажлын нэг хэсэг нь СББӨ-ийн бүртгэлийг цахимжуулах ажил байсан бөгөөд энэ ажил нь нь одоог хүртэл хийгдээгүй байна. Өвлөн уламжлагчдын бүртгэлд хамрагдалтын

судалгаанаас 85 орчим хувийг орон нутгийн мэргэжилтнүүд олж тодруулж байгаа нь орон нутгийн Соёлын өвийн мэргэжилтний үүрэг өндөр байгаа ч мэргэжилтний мэдлэг, ур чадвар сул байгаа нь үзлэгийн явцад ажиглагдсан.

Сүхбаатар аймаг:

Сүхбаатар аймгийн СББӨ-ийн онцлох ай, өвийн төрлүүд түүхэн хөгжлийн үйл явцтай гүнзгий холбоотой юм. Одоогийн Сүхбаатар аймгийн нутагт 1697 онд Манж Чин улсын хааны зарлигаар анх адуун сүрэг байгуулсан бөгөөд одоо ч Сүхбаатар аймаг нь хурдан угшлын адуу ихтэй, улс, аймаг, бүсийн хэмжээний уралдаанд Сүхбаатарын угшилтай адуу үзүүр түрүүнд хурдалдаг нутаг билээ. Мөн Дарьганга хошуу эртнээс дархан урлалаар алдартай байсан нутаг билээ.

- Уламжлалт гар урлал үүнд Дарьганга дархан урлал, Сүхбаатар аймаг мод багатай газар хэдий ч модон сийлбэр урлал, эсгий ширмэл урлал голлож байна.
- Мал маллах уламжлалт арга ухаан ай дотор Адууны соёл Сүхбаатар аймагт өргөн дэлгэр тархсан.
- Ардын язгуур урлагийн ай сав дотор Морин хуур хөгжим урлал, морин хуурын татлага, Уртын дуу зэрэг онцлох өвийн төрлүүд байна.

Сүхбаатар аймгийн СББӨ-д хийсэн цахим судалгааны тоон болон аналитик үзүүлэлт нэгтгэн дүгнэлт хийвэл, Халх угсаатан 44 хүн, Дарьганга угсаатан 39 хүн, Үзэмчин 4 хүн хамрагдаж угсаатны бүлэг хамрагдаж бусад угсаатны бүлгээс 2 хүн хамрагдсан байна, Мөн үзлэг судалгаанд хамрагдсан өвлөн уламжлагч нарын 96 хувь нь аймгийн уугуул, 75 хувь нь сумын уугуул иргэд байна. Насны бүтцийн хувь 60-80 насны иргэд хамгийн олон буюу 30 хувь эзэлж байна. Мөн 46-60 насны 25 дээш хувь, 36-45 хувь нь 10 гаруй хувь, харин 80 аас дээш насны хүн хамгийн бага 7 хувь байна.

Ажил мэргэжлийн хувьд 23 хувь нь малчин иргэд бөгөөд 43 хувь нь тэтгэврийн насны иргэд, дөнгөж 16 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч бөгөөд өвлөн уламжлагч нарын орлогын эх үүсвэр нь цалин тэтгэвэр малаас хүртсэн ашиг шим давамгайл байна. Ийм учир төрөөс СББӨ-ийн өвлөн уламжлагч нарт төрөөс тодорхой дэмжлэг шаардлагатай.

СББӨ-ийг орон нутагтаа эдийн засгийн эрэлтэд оруулах шаардлагатай хэмээн хариулжээ. СББӨ-ийн өвлөн уламжлагч нар дундаа ардын язгуур

урлагтай холбоотой өвлөн уламжлагч нар нь өвөөс хүртэх ашиг орлого гэх зүйл байхгүй бөгөөд цаашид эдгээр өвлөн уламжлагч нартаа тодорхой дэмжлэг үзүүлэх шаардлагатай. Мөн судалгаанд хамрагдсан өвлөн уламжлагч нарын 68 хувь нь угийн бичиг хөтөлдөггүй хэмээн хариулсан бөгөөд энэ нь Сүхбаатар аймгийн угсаатны бүлгийн түүхэн бүрдэлтэй холбоотой байж болно.

СББӨ-ийн тогтвортой байдал хойч үедээ уламжлуулах байдал нь 68 хувь нь эцэг эх гэр бүлийн хүрээнд өвлөн уламжилсан ба 2-3 дах үеийн өвлөн уламжлагч нарын 56 хувь 3–аас дээш үеийн өвлөн уламжлагч 15 хувь байна. Дарханы урлалаас бусад өвийн хүрээнд өвлөн уламжлуулах үйл явц харьцангуй тогтвортой байна.

Орон нутгийн хэмжээнд өвлөн уламжлагч нарыг эдийн засаг санхүүгийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх соёлын бүтээлч үйлдвэрлэл нэвтрүүлэх, Өвийн төрөл бүтээгдэхүүн үйлдвэрлэж өрхийн орлого нэмэгдүүлэх зорилгоор хэрэгжүүлсэн хөтөлбөрүүд олон бөгөөд үүнд голцуу уламжлалт цагаан идээ боловсруулах арга ухаан, эсгийн хийх, эсгий ширмэл урлал, суран эдлэл, модон эдлэл зэрэг төрлүүд голчлон хамрагдсан байна.

Хурдан морины соёл сайн хадгалагдан үлдсэн нь эдийн засгийн эргэлт сайтай орон нутаг нь өөрөө /Сүхбаатарын хурдан угшлын адуу нь/ зах зээлд брэнд болж чадсантай холбоотой.

Сүхбаатар аймгийн Соёл урлагийн газар идэвх хичээл зүтгэл сайтай залуу боловсон хүчнээс бүрдсэн хамт олон бөгөөд хээрийн судалгааны 22 хоногийн турш харилцаа холбоо сайтай байж очсон сум бүр дээр СББӨ-ийн өвлөн уламжлагч нартаа холбох уулзуулах ажлыг сайн зохион байгуулсан хэмээн дүгнэж байна.

Дорнод аймаг:

Бид тоон болон чанарын судалгааны арга зүйгээр цуглуулсан эх хэрэглэгдэхүүнд тулгуурлан Монголчуудыг Монголоор нь байлгаж буй соёлын аргамж нь соёлын биет бус өв, түүнийг өвлөн уламжлагчид хэмээн үзэж байна.

Нэгт, Дорнод аймгийн соёлын аргамжны хэмжээ. Дорнод аймаг бол Монгол улсын зүүн хязгаарт орших Халх, Буриад, Үзэмчин угсаатны бүлгээс бүрдсэн аймаг юм. Байгалийн тогтцын хувьд хойд хэсгээрээ ойт хээр, хээрийн бүс, дунд болон өмнөд,

зүүн, баруун хэсгээрээ тал хээрийн бүст оршдог. Энэ утгаараа тал нутагт тайван амгалан аж төрж байна. Дорнод аймгийн хэд хэдэн сум САА аж ахуй түшиглэн байгуулагдсан тул Монгол улсын өнцөг булан бүрээс цугласан хүн амаас бүрддэг. Энэ нэг талаараа олон соёлын нийлэгжил бий болгох үндэс болсон байна. Өөрөөр хэлбэл Дорнод аймагт орших соёлын аргамжны орон зайд Монгол улсын олон угсаатны бүлгийн онцлог байхаас гадна хил залгаа БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Барга, Үзэмчин, Буриад угсаатны бүлэг, ОХУ-ын БН Буриад улсын Буриад Монголчууд соёлын хувьд нягт харилцаатай байна. Энэ нь Дорнод аймгийн соёлын биет бус өвийн орон зайг тодорхойлоход чухал хүчин зүйл болж байна. Энэ бидний соёлын аргамжны орон зайд тэдний хувь нэмэр чухал нөлөө үзүүлж байгааг бид угсаатны бүлэг ба түүнд тулгуурласан соёлын наадмуудын хүрээнд авч үзсэн билээ (2.1 үзнэ үү). Бидний дорнод аймгийн соёлын аргамжийг бөхөлж буй нэг хүчин зүйл нь угсаатны бүлэгт тулгуурласан соёлын наадам хэмээн үзэж байна.

Хоёрт, Дорнод аймгийн соёлын аргамж ба соёлын биет бус өв өвлөн уламжлагчид:

Дорнод аймгийн хувьд соёлын биет бус өв өвлөн уламжлагчийн өнөөгийн байдал гундуу байна. Тухайлбал, зарим өвлөн уламжлагч нар амьдралын боломж муу, амьдралын шаардлагаар өөр зүйл хийж, мэдлэг, уламжлалаа залуучуудад өвлүүлэх, түгээн таниулах тал дээр цалгардаж байна. Нөгөө талаараа тэднийг үнэлэх нийгмийн үнэлэмж доогуур байгаа нь тус аргамж гандах үндсэн шалтгаан болж байна. Мөн хорвоогийн жамыг даган өндөр настай өвлөн уламжлагчид тэнгэрт дэвшиж байгааг бид бодолцох шаардлага байна. Мөн бид тус соёлын аргамж болж буй өвлөн уламжлагчаа тордох, өнгөлөхөд хөрөнгө зарцуулах, дэмжиж туслах шаардлага байна.

Гурав, Дорнод аймгийн соёлын аргамжны алтан гадас ба настнууд

Монголчууд мал аж ахуйн соёлтой тул гадас хэдий сайн ч аргамж муу бол морь тогтохгүй гэдгийг сайн мэднэ. Үүний нэгэн адил гадас нь муу бол аргамжаа бөхөлсний хэрэг гардаггүй. Соёлын биет бус өвийн тухайд асар үнэ, хүндтэй эрхмүүд бол ахмадууд юм. Тэднээс бид соёлын мөн чанар, уламжлалт ёс, зан үйл гэх мэт маш олон зүйлийг сурвалжлан аргамжиж авах шаардлага байна. Бид яарахгүй бол тэд хүлээхгүй. Ахмад настнуудыгаа идэвхжүүлэн залуу үедээ өвлүүлж буй сайн жишээ Дашбалбар, Баян-Уул сумдад байна. Дашбалбар суманд “Нутгийн домог”, Баян-Уул суманд “Наранбулаг” гээд ахмадын хамтлаг үр дүн өндөртэй ажиллаж байна. Гэхдээ энэ

бол нэг л арга юм. Бид маш богино хугацаанд олон аргаар ахмадуудтайгаа тулж ажиллаж, сум, аймгийнхаа өв соёлыг тэмдэглэн авч үлдэх, өвлөн уламжлуулах хэрэгцээ нэн шаардлагатай байна.

Дөрөв, Дорнод аймгийн аргамжны эзэд ба соёлын өвийн ажилчид, Соёлын төв

Дорнод аймагт өвийн ажилтнуудыг соёлын өвийн талаарх мэргэжил арга зүйгээр хангаж, тэдний ажлын нөхцөлд анхаарлаа хандуулах, тоног төхөөрөмжөөр хангах зайлшгүй шаардлага байна. Үндэсний хөгжимтэй сум цөөхөн байна. Дорнод аймгийн төвд Л.Идэрбат багш шавь сургалт зохион байгуулж олон хүнд уртын дуу заажээ. Тэд бэсрэг уртын дууг голчлон дуулж байна. Тэдний дууны урын сан бага, дуулах чадвар дутмаг байна. Сургалтыг цаашид эрчимжүүлэх шаардлагатай хэмээн үзлээ.

Дээрх санаагаа нэгтгэн дүгнэж үзвэл Дорнод аймгийн соёлын бит бус өвийн тухайд уламжлалт гар урлалын өвийн төрөл зүйлээс Буриад хувцасны уламжлалт урлал, Халх хувцасны уламжлалт урлал, Бөөгийн хувцас урлал, Монгол гэрийн уламжлалт урлал, Эсгий ширмэл урлал, Монголын уламжлалт модон эдлэлийн урлал, эмээл хийх урлал, үйсэн урлал, модон сийлбэрийн урлал харьцангуй түгээмэл хадгалагдаж байна. Харин үндэсний нум сум урлал нь Манж Чин улсын үед Монголд дэлгэрсэн урт, том нум сумны урлал Баяндун суманд хийгдэж байна. Нум сумны урлалыг дундад зууны Монгол нум сумны хэлбэр хийц рүү чиглүүлэх шаардлагатай байна. Монгол дархны уламжлалт арга ухаан, баримлын урлал, шуумлын урлал, зээгт наамлын уламжлалт урлал, ходок тэрэг хийх уламжлалт арга ухаан харьцангуй бага аймаг сумын хэмжээнд нэг хоёр л хүнд хадгалагдаж байна.

Нутаг нутагт цагаан идээ боловсруулах, морь, бөх цоллох, арьс ширэн эдлэл, модон эдлэл, гэрийн мод урлал нь хүмүүсийн эрэлт хэрэгцээнд үндэслэн хийгддэг тул харьцангуй сайн хадгалагдан үлджээ. Харин зан үйл болон төдийлөн хийгдээд байдаггүй өв соёлууд ерөнхийдөө тасарсан маягтай байна. Үүнд: хүүхэдтэй холбогдох зан үйлүүд, байгаль шинжих арга ухаан, нүүдэл хийх уламжлалт арга зэрэг өвүүд орж байна.

Халхгол суманд Буйр нуурыг үзэхээр ирж буй дотоодын аялагчдын тоо жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа тухай нутгийнхан ярьж байна. Энэ аяллыг түшиглэн “Соёлын үйл ажиллагаа” зохион байгуулах, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх шаардлагатай байна.

Улаанбаатар хот:

Бүртгэн баримтжуулалт

Аймаг, нийслэлийн Соёлын байгууллагын ажилтан (музейн БМСанч) ажлаас гарах, дэвших зэргээр солигдож байгаатай холбоотой бүртгэл мэдээллийн сангийн хадгалалтын аюулгүй байдал маш хангалтгүй сул байна. (БМСангийн мэдээлэл устаж алга болох тохиолдол гарсаар байна.) Иймд БМСангийн хадгалалтын аюулгүй байдалд хяналттай байя.

Дүүргүүдийн СББӨ-ийн бүртгэлтэй танилцахад шинээр өвлөн уламжлагчийг нэмэх, хасах, шилжилт хөдөлгөөний тэмдэглэлийг огт хийгээгүй дутагдалууд байна. Цаашид СББӨ-ийн бүртгэлд шинээр өвлөгчийг таньж тогтоох, бүртгэх ажлыг тухайн аймаг, сум, дүүргийн ЗДТГ-ын дэргэдэх орон тооны бус зөвлөлөөр хэлэлцүүлэн бүртгэж авдаг байсан өмнөх тогтолцоог СББӨ-ийг бүртгэх тухай шинэчилсэн журамд тусгаж оруулах нь зүйтэй Соёлын өвийн чиглэлээр арга хэмжээ 2022 онд огт төлөвлөөгүй, хийгээгүй дүүргүүд байна. Иймд өв, өвлөн уламжлагчийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, өвийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажлыг төлөвлөн хэрэгжилтийг нь хянах цаг нэгэнт болжээ.

Өвийн тухайд

СББӨ, өвлөн уламжлагчийг хамруулах түүвэр судалгааг хийхдээ засаг захиргааны онцлог байдлаас үүдэн Нийслэлийн бүсэд “Мал маллах арга ухаан” ай савыг оруулаагүй , бусад 6 ай савын хүрээнд хийсэн.

Нийслэлийн 9 дүүргээс СББӨ-ийн Төлөөллийн үндэсний бүртгэлийн 6 ай савд хамаарах 33 өв, Яаралтай хамгаалах шаардлагатай СББӨ-ийн 2 ай савд хамаарах 7 өв, Юнескогийн СББӨ -ийн 3 ай савд хамаарах 3 өвийг хамруулсан.

Монголын ард түмний СББӨ уламжлагчдын багагүй хэсэг нь эх орны нийслэл Улаанбаатар хотноо аж төрж байна. Иймээс Улаанбаатар хот бүхэлдээ монголын олон угсаатны соёлын өв уламжлалыг хадгалж, тээж байгаа өвөрмөц соёлын хот юм.

Малчин ардын болон хүрээ төвшний соёлын уг үндэс, язгуур угсаа урьдын бий болсон хүрээ маягийн дуу, хөгжим соёлын уламжлал нийслэл хотод байсан. Энэ уламжлал бүдгэрч ардын болон хүрээ дууны онцлог аялгуу, чамин сайхан нугалаа ая данг мэддэг хүн цөөхөн болжээ.

Судалгаагаар гар урлал, угийн бичиг, бариа засал гэсэн өвүүд бусад өвийн төрлөөс олон байгаа нь ажиглагдав. Уламжлалт гар урлалын ай сав хамаарах модон эдлэл, дарханы урлал, бариа засал, эсгий урлал зэрэг өвд хамаарах өвлөн уламжлагчид

		<p>нь бие даасан урлан, цехтэй болтлоо өргөжиж өвөөрөө дамжуулан өрхийн орлогоо дээшлүүлж байна.</p> <p>Өвлөн уламжлагчид</p> <p>Энэ удаагийн үзлэгээр нийслэлийн бүх дүүргүүд зохион байгуулалтын хувьд маш хангалтгүй оролцсон. Судалгаанд хамрагдах өвлөн уламжлагчдад судалгааны зорилго чиглэлийн талаар буруу мэдээлэл өгч ирүүлсэн нь судалгаанд хамрагдах хүмүүс гээгдэж орхигдох тал ажиглагдсан. Мөн өвлөн уламжлагчдын өвийн талаарх мэдлэг ойлголт сул байна.</p> <p>Нийслэлийн дүүрэг болгонд ардын язгуур урлагийн хамтлагуудтай, соёл, урлагийн арга хэмжээ болон бие даасан уран бүтээлийн тоглолт хийж өрхийн орлогоо дээшлүүлж байна. Эдгээр ахмад өвлөн уламжлагчдад төр, захиргааны байгууллагын дэмжлэг байхгүй байгааг онцлох нь зүйтэй.</p>
1.1.8	Судалгаа хийсэн СББӨ-ийг төлөөллийн болон яаралтай хамгаалах жагсаалтад оруулах, хасах, хадгалан хамгаалах санал боловсруулах;	<p>Судалгааны багийн судлаач нарын саналыг энэхүү тайланд нэгтгэсэн болно.</p> <p><u>Судалгааны хүрээнд:</u></p> <ul style="list-style-type: none"> - Жонш, чулуугаар урлах урлал <p><u>Цаашид жагсаалтад оруулах санал</u></p> <ul style="list-style-type: none"> - Хамниган зүйр цэцэн үг - Барга Хамниган нүүдлийн тэрэг - Хоточ нохой сургах арга ухаан - Бие хамгаалах урлаг - Сархинаг боловсруулах арга ухаан - Хамниган хөзөр тоглох арга ухаан гэх мэт.
1.1.9	Үзлэг, судалгааны мөрөөр авах арга хэмжээний санал боловсруулах;	<ul style="list-style-type: none"> - Хэнтий аймаг нь эртний язгуур шүтлэг, бөө мөргөл, бурхны шашин дэлгэрсэн нутаг бөгөөд энэ чиглэлийн үнэт соёл, ёс уламжлал гэх зүйл төдийлөн байхгүй болжээ. Тиймээс судалгааны төрөлжсөн мэргэжлийн байгууллагатай хамтран хүүхэд залуус, идэр насныхан энэ чиглэлээр өөрсдийн соёлын бахархлыг буй болгох шаардлагатай. - СББӨ-ийн чиглэлээр хэрэгцээ шаардлагатай, бүс нутаг, аймгийн шинж чанартай үр ашигтай төсөл хөтөлбөрийг байгалийн нөөц баялаг, хүмүүсийн чадавх, сумдын онцлогт нийцүүлэн системтэй хэрэгжүүлэх, улс, аймгийн хэмжээнд шавь сургалтын үр дүнг илүү онцлох, олон нийтэд сурталчлах, багш-шавь гэдэг уламжлалыг сурталчлах арга хэмжээг зохион байгуулах, шилдэг өвлөн уламжлагчдыг алдаршуулах, тэдэнд илүү боломж нөхцөлийг хангаж өгөх, энэ талаар сурталчилгаа хийх,


		<ul style="list-style-type: none"> - Сум орон нутаг, сум хөгжүүлэх сангаас хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрт өвлөн уламжлагчдыг эхний ээлжид хамруулдаг байх, - Тайланг зөв зохистой гаргаж, зөв сурталчлах, - Сумын засаг дарга нарын мөрийн хөтөлбөрт тусгуулдаг байх, - Өвлөн уламжлагчдын өвлөж буй бүтээл, өв уламжлалд орж буй өөрчлөлтийн талаар хэлэлцүүлэг хийх, соёлын бүтээлч үйлдвэрлэл, өрхийн үйлдвэрлэл ялгаа заагийг тодруулах - Салбарын шат шатны байгууллагууд “Соёлын биет бус өвийн үзлэг, бүсчилсэн судалгаа” -ны ажилд дүн шинжилгээ хийж үзлэгийн мөрөөр арга хэмжээг авч тайлагнадаг байх, - Аймаг, нийслэл, дүүргийн Соёлын байгууллагын ажилтан (музейн БМСанч) ажлаас гарах, дэвших зэргээр солигдож байгаатай холбоотой бүртгэл мэдээллийн сангийн хадгалалтын аюулгүй байдал сул байна. (БМСангийн мэдээлэл устаж алга болох тохиолдол гарсаар байна.) Иймд БМСангийн хадгалалтын аюулгүй байдал хяналт тавих, - СББӨ-ийн Улсын үзлэгт тооллогод шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, - Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын цахим хичээлийн платформд соёлын өвийн талаарх мэдлэг, ойлголт олгох цахим хичээл хязгаарлагдмал (1-2 сэдвийн хүрээнд) цөөн байгааг мэргэжлийн сургагч, судлаачид онцолж үүнийг цэцэрлэг, бага, дунд, ахлах ангид хөтөлбөр боловсруулж, түгээн сурталчлах.
1.1.10	СББӨ, өвлөн уламжлагчийг гэрэл зураг, дуу, дүрс бичлэгээр баримтжуулж, Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санг баяжуулах.	<p><u>Дорнод аймаг</u> Нийт 3964 ширхэг бүхий 703 GB хэмжээтэй цахим сан үүсгэв.</p> <p><u>Сүхбаатар аймаг</u> Нийт 424 GB хэмжээтэй дүрс бичлэг гэрэл зургийн хамт бүрдүүлэв.</p> <p><u>Хэнтий аймаг</u> Нийт 127 минут 8 секундйн хугацаатай үргэлжлэх 232.5 MB дуу бичлэг, 113.5 GB хэмжээтэй 1481 гэрэл зураг болон 1835.3 минут буюу 30.5 цагийн</p>

		<p>хугацаатай үргэлжлэх 582 GB хэмжээтэй дүрс бичлэг бүрдүүллээ. Нийт файлын хэмжээ 3964 ширхэг бүхий 703 GB байна.</p> <p><u>Нийслэл Улаанбаатар хот</u> Нийт 749 минут буюу 12 цагийн хугацаатай үргэлжлэх 223.3 GB хэмжээтэй дүрс бичлэг, 1.72 GB хэмжээтэй 442 ширхэг гэрэл зураг дүрс бичлэг бүрдүүллээ. Нийт файлын хэмжээ 714 ширхэг бүхий 235 GB байна.</p> <p>Зураг авалтад ашигласан тоног төхөөрөмж:</p> <ul style="list-style-type: none">• Дуу бичлэгийг Zoom H6 ашиглан MP3 форматаар,• Дүрс бичлэгийг GoPro Hero 9, Nikon D850, Nikon D7000 ашиглан Full HD 1080 болон 4K нягтаршил бүхий MOV, MP4 форматаар,• Гэрэл зургийг Nikon D850, Nikon D7000 ашиглан JPEG, RAW формат ашиглан авав.
--	--	--

1.2. СББӨ-д хийсэн цахим судалгааны тоон болон аналитик үзүүлэлт



Зураг 1 /нийт 314 өвлөн уламжлагч хамрагдсан/ Зураг 2 /нийт 336 өвлөн уламжлагч хамрагдсан/



Зураг 3 /нийт 335 өвлөн уламжлагч хамрагдсан/

Судалгаанд хамрагдсан нийт өвлөн уламжлагчдын 48 хувь нь 61-80 настай, 28 хувь нь 46-60 настай, 11 хувь нь 36-45 настай байгаа нь өвлөн уламжлагчдын ихэнх нь 87 орчим хувь нь 46-аас дээш насныхан байв.

1.9. Та хаана амьдарч байна вэ? Хариултаа сонгоно уу?				
Аймаг, нийслэл	Аймаг	Үгүй	Сум / дүүрэг	Үгүй
Нийслэл			34	64
Дорнод	69	9	62	16
Сүхбаатар	76	3	20	39
Хэнтий	69	10	55	24
Нийт	214	22	171	143




Хүснэгт 1/нийт 335 өвлөн уламжлагч хамрагдсан/

Зураг 4 /нийт 324 өвлөн уламжлагч хамрагдсан/

Өвлөн уламжлагчдын нийгмийн асуудлыг тодруулахад тэдний боловсролын асуудлыг танин мэдэх нь ихээхэн чухал байв. Учир нь боловсролын асуудал нь эрүүл мэнд, өрхийн орлогын үндэс суурь үзүүлэлт болж байдаг.

Судалгаанд хамрагдсан өвлөн уламжлагчдын 97 буюу 30 хувь нь дээд боловсролтой, 56 буюу 17 хувь нь тусгай мэргэжилтэй бол 88 буюу 27 хувь нь бүрэн дунд, бүрэн бус дунд боловсрол 63 буюу 20 хувь, 6 хувь бага боловсролтой гэсэн статистик дүн гарч байна. Харин хөдөлмөр эрхлэлтийн хувьд 49 хувь тэтгэврийн насных бол 17 хувь нь төрийн байгууллагад, 16 хувь малчин, 12 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг, 5 хувь нь хувийн хэвшлийн байгууллагад ажилладаг байна.



Зураг 5 /нийт 335 өвлөн уламжлагч хамрагдсан/

1.14. Танд Төр засгаас олгосон одон медаль, гавьяа шагнал? /Олон хариулт сонгож болно/								
Аймаг, нийслэл	Жуух бичиг	Тэргүүний ажилтан	Алтан гадас	Соёлын гавьяат зүтгэлтэн	Урлагийн гавьяат зүтгэлтэн	Хөдөлмөр ийн хүндэт	Төр, засгаас олгосон	Бусад
Нийслэл	25	60	28	4	0	4	21	11
Дорнод	16	17	10	1	0	1	43	9
Сүхбаатар	10	23	21	0	1	6	20	7
Хэнтий	8	18	14	3	1	8	26	26
Нийт	59	118	73	8	2	19	110	53

Хүснэгт 2 /нийт 335 өвлөн уламжлагч хамрагдсан/

1.21. Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн бүртгэлд хэрхэн хамрагдсан бэ? Хариултаа сонгоно уу?				
Аймаг, нийслэл	Өөрийн хүсэлтээр	Судлаачдын таньж тогтоосноор	ОНБ ажилты тогтоосноор	Мэдэхгүй
Нийслэл	22	4	24	10
Дорнод	1	29	43	2
Сүхбаатар	1	11	66	5
Хэнтий	1	1	66	2
Нийт	25	45	199	19

Хүснэгт 3 /нийт 288 өвлөн уламжлагч хамрагдсан/



Зураг 6 /нийт 288 өвлөн уламжлагч хамрагдсан/

Өвлөн уламжлагчийн бүртгэлд хамрагдалтын судалгаанаас 69 орчим хувийг орон нутгийн мэргэжилтнүүд, 16 хувийг судлаачид олж тодруулж байгаа нь орон нутгийн соёлын төвийн мэргэжилтний үүрэг өндөр байгааг харуулж байна.

1.22. Та соёлын биет бус өвийн авьяасаа хэрхэн өвлөн уламжилсан вэ? Хариултаа сонгоно уу?						1.23. Та хэд дэх үеийн өвлөн уламжлагч хүн бэ? Хариултаа сонгоно уу?				
Айм Аймаг, нийслэл аг, нийслэл	Өөрийн ойрын гэр бүлээс	Төрөл садан, хамаатнаас	Шавь сургалтаар	Бие дааж сурсан	Танхимын сургалтаар	Аймаг, нийслэл	1 дэх үе	2 дахь үе	3 дахь үе	4 дэх үе
Нийслэл	36	10	10	33	10	Нийслэл	41	18	29	11
Дорнод	41	4	13	14	5	Дорнод	36	28	3	11
Сүхбаатар	62	7	5	3	6	Сүхбаатар	23	32	19	13
Хэнтий	43	9	4	18	5	Хэнтий	30	22	17	10
Нийт	182	30	32	68	26	Нийт	130	100	68	45

Хүснэгт 4 /нийт 338 өвлөн уламжлагч хамрагдсан/



Зураг 7 /нийт 338 өвлөн уламжлагч хамрагдсан/

Өв уламжлагдах байдлын хувьд өөрийн ойрын гэр бүл, төрөл садан, хамаатан, шавь сургалт зэрэг ахуй амьдралаасаа сурч мэдсэн нь 72 хувь, танхимын сургалтаар 8 хувь, бие дааж 20 хувь нь сурсан нь соёлын биет бус өв харьцангуй язгуур чанараа алдаагүй байгаа хэрэг юм. Энэ нь өвлөн уламжилсан хэлбэрүүдийн үзүүлэлтээр баталгаажиж байгаа бөгөөд

54 хувь нь гэр бүл, 9 хувь нь төрөл садангаасаа, 9 хувь нь шавь сургалтаар сурчээ. Тиймээс соёлын өвийг уламжлан хадгалах цаашдын хандлагыг энэ чиглэлд илүү анхаарах.




Зураг 8 /нийт 343 өвлөн уламжлагч хамрагдсан/

Өв өвлөгдөх байдлыг судалгаанаас харахад 1 дэх үедээ өвлөгчид олон бол 4 дахь үедээ өвлөгчид хамгийн цөөн буюу 13 хувьтай гэсэн баримт нь анхаарах ёстой үе хэдийн ирсэнг мэдээлж, дорвитой арга хэмжээ зайлшгүй шаардлагатайг анхааруулж байна.

Мөн 1 дэх үеийн өвлөн уламжлагчид гол төлөв ахуйгаасаа бие даан суралцаж буй нь тухайн өвийн зүйлийн ач холбогдол алдагдаагүй эрэлт хэрэгцээ байгааг илэрхийлж байгаа нь сайшаалтай. Иймд залгамж халааг нь бэхжүүлэх, тогтвортой хөгжихөд чиглэсэн бодлого шаардлагатай.

Учир нь өвлөн уламжлагч нарын үе дамжсан байдлын дүн мэдээнээс 1- 2 дахь үеийн өвлөн уламжлагч нарын тоон дүн давамгайл байсан нь цаашид тухайн СББӨ нь өөрчлөлтөд орох магадлал өндөр буйг илэрхийлж буй, мөн СББӨ-ийн утга, агуулга гуйвах үүнээс улбаалаад ач холбогдол, үнэ цэн нь буурах эрсдэл үүсэж болзошгүй. Иймд цаашид энэ чиглэлээр нарийвчилсан, харьцуулалт судалгаа зайлшгүй шаардлагатай байна.

Та СББӨ-ийг өвлүүлэн уламжлуулж байна уу



Зураг 9 /нийт 343 өвлөн уламжлагч хамрагдсан/


Судалгаанд хамрагдсан өвлөн уламжлагчдын 79 хувь эзэмшиж буй өвөө тодорхой хэмжээнд өвлөн уламжлуулж байгаа бол 21 хувь нь ямар нэг хэмжээгээр өвлүүлж уламжлуулж амжаагүй байгаа үр дүн гарсан. Соёлын биет бус өв нь нийгмийн амьдрал дээр ахуй хамаатан садан, нутгийнхандаа өвлүүлэх байдал түгээмэл байна. Тухайлбал, 178 өвлөн уламжлагч буюу 61 хувь нь ахуй амьдрал дээр, 72 өвлөн уламжлагч буюу 25 хувь нь шавь сургалтаар өвлүүлэн уламжлуулж буй нь СББӨ-ийн үнэ цэн, ач холбогдол өндөр буйг илэрхийлж буй хэдий ч нөгөөтээгүүр судалгаанд оролцсон өвлөн уламжлагч нарын СББӨ-ийг өвлөн уламжилж буй үе дамжсан нөхцөлтэй харьцуулахад харьцангуй өрөөсгөл тоо гарч ирж буй нь анхаарал татаж байна.

Өөрийн өвлөн уламжилсан СББӨ-ийг хойч үед өвлүүлэн уламжлуулах, сургах ажлыг тогтмол хийж чадаж буй эсэх талаар 32 хувь нь тийм, 41 хувь нь заримдаа, 27 хувь нь үгүй хэмээн хариулсан байна. Иймд ямарваа нэгэн байдлаар өвлүүлэн уламжлуулах ажлыг эрчимжүүлэх зайлшгүй шаардлага буйг дээрх хариулт харуулж байна.



Зураг 10 /нийт 343 өвлөн уламжлагч хамрагдсан/

СББӨ-ийг үйлдэх арга барил хувиран өөрчлөгдсөн эсэх тухайд 76 хувь нь үгүй, 24 хувь нь тийм хэмээн хариулсан бөгөөд хувиран өөрчлөгдөх шалтгаан нь 43 хувь нь техник, технологийн өөрчлөлт, 28 хувь нь орчин үеийн түүхий эд ашиглах, 10 хувь нь үнэ цэн, ач холбогдол буурсан, 4 хувь нь жендерийн эрх тэгш байдал, нас, хүйсийн онцлог, 16 хувь нь бусад шалтгаан хэмээн тайлбарлажээ.



Зураг 11 /нийт 290 өвлөн уламжлагч хамрагдсан/

2.1. Та СББӨ-ийг өвлүүлэн уламжлуулж байна уу? Хариултаа сонгоно уу?			2.2. Хэрэв ТИЙМ бол ямар хэлбэрээр өвлүүлдэг вэ? Хариултаа сонгоно уу.?				2.3. Та өөрийн эзэмшсэн СББӨ-ийг хойч үед өвлүүлэн уламжлуулах, сургах ажлыг тогтмолжуулж чадсан уу? Хариултаа сонгоно уу?		
	Тийм	Үгүй	Шавь сургалтаар	Албан сургалтаар /анги, танхим/	Ахуй амьдрал дээр	Бусад	Тийм	Заримдаа	Үгүй
Нийслэл	81	18	28	7	46	8	36	35	28
Дорнод	56	22	10	12	36	1	28	22	28
Сүхбаатар	67	20	16	6	48	2	32	29	26
Хэнтий	66	13	18	4	48	0	14	53	12
Нийт	270	73	72	29	178	11	110	139	94

Хүснэгт 5 /нийт 335 өвлөн уламжлагч хамрагдсан/



Зураг 12 /нийт 343 өвлөн уламжлагч хамрагдсан/

2.4. СББӨ-ийг үйлдэх таны арга барил хувиран өөрчлөгдсөн үү? Хариултаа сонгоно уу?			2.5. Хэрэв таны хариулт ТИЙМ бол, ямар шалтгааны улмаас хувиран өөрчлөгдсөн талаар бичнэ үү? Хариултаа сонгоно уу?				
Аймаг, нийслэл	Тийм	Үгүй	Техник, технологийн нөлөө	Боловруулсан орчин үеийн түүхий эд ашиглах	Үнэ цэн, ач холбогдол нь буурсан	Жендерийн эрх тэгш байдал, соёлын урсгал, нас, хүйсийн онцлог гэх мэт	Бусад
Нийслэл	35	64	16	16	7	4	0
Дорнод	5	73	3	2	1	0	0
Сүхбаатар	25	62	18	5	0	0	8
Хэнтий	17	62	8	5	2	0	9
Нийт	82	261	45	28	10	4	17

Хүснэгт 6 /нийт 335 өлөн уламжлагч хамрагдсан/


Харьяа засаг захиргааны нэгжээс танд дэмжлэг үзүүлдэг эсэх тухайд 68 хувь нь үгүй хэмээн хариулсан нь СББӨ-ийг хамгаалах, тогтвортой хөгжих, хөхиүлэн дэмжих тал дээр сум, дүүрэг, орон нутгийн түвшинд бодлого, чиглэсэн арга хэмжээ сул буйг илэрхийлж байна. Тийм хэмээн 9 хувь, заримдаа 18 хувь, мэдэхгүй 5 хувь нь тус тус хариулсан нь хууль эрх зүйн орчин бүрдээгүй, хэрэгжилт сул байгааг харуулж байна.

Цаашлаад өвийг тогтвортой үйлдэхэд ямар дэмжлэг шаардлагатай байгаа талаар мөнгөн урамшуулал 17 хувь, байр танхимаар хангах 17 хувь, төсөл санхүүгийн дэмжлэг 16 хувь, материаллаг хэрэглэгдэхүүн 14 хувь, уралдаан, наадамд тогтмол оролцох 12 хувь, үйл ажиллагааны зардал 5 хувь зэргээр хариулсан нь өвлөн уламжлагч нарт төсөл, санхүү, урамшууллаас гадна үйл ажиллагаагаа тогтмол явуулах байр, материаллаг дэмжлэг хэрэгцээ шаардлагатай байгааг илэрхийлж байна.

2.6. Харьяа засаг захиргааны нэгжээс танд дэмжлэг үзүүлдэг үү?				
Аймаг, нийслэл	Тийм	Заримдаа	Үгүй	Мэдэхгүй
Нийслэл	13	28	45	13
Дорнод	3	7	67	1
Сүхбаатар	13	18	53	3
Хэнтий	3	7	67	1
Нийт	32	60	232	18

Хүснэгт 7 /нийт 342 өвлөн уламжлагч хамрагдсан/

Өвлөн уламжлагчдын эрүүл мэнд, амьдралын хэвшлийг асуумж, ярилцлагаар тодруулж, амьдралын чанарын нөхцөл байдал дүн шинжилгээ хийв. Өвлөн уламжлагчдын эрүүл мэнд, амьдралын хэвшлийг асуумж, ярилцлагаар тодруулж, амьдралын чанарын нөхцөл байдал дүн шинжилгээ хийв.



Зураг 13 /нийт 335 өвлөн уламжлагч хамрагдсан/

Судалгаанд хамрагсдын 70 хувь эрүүл мэндэд анхаарч чаддаг гэсэн нь өвлөн уламжлагч нарын насны бүтэцтэй шууд хамааралтай байх магадлалтай учир нь 28 хувь 60-80 настай иргэд 3.6 хувь нь 80 дээш насны тэтгэврийн иргэд учир эрүүл мэндийн байдалд анхаарал хандуулан тодорхой эрүүл мэндийн үйлчилгээг тогтмол авдаг. Мөн СББӨ –ийн өвлөн

уламжлагч нарын хөдөлмөр эрхлэлтийн байдлаас хамааралтай бөгөөд төрийн албан хаагч нар жил бүрийн урьдчилан сэрээлэх үзлэг, оношилгоонд хамрагдаж буй тул эрүүл мэндийн байдал тодорхой хянаж чаддаг хэмээн хариулж байна харин эрүүл мэнддээ анхаардаггүй гэсэн хариултын голдуу малчид хувиараа хөдөлмөр эрхэлж буй иргэд хариулсан нь анхаарал татаж байна хэмээн судлаач нар дурдсан байв.

1.29. Та ямар зорилгоор эмчийн хяналтад ордог вэ? Хариултаа сонгоно уу?					
Аймаг, нийслэл	Урьдчилан сэргийлэх	Биед ямар нэгэн зовуурь илрэх	Өвдсөн үед	Байнгын хяналтад байдаг	Хяналтад ороогүй байгаа
Нийслэл	22	23	16	16	22
Дорнод	41	14	9	10	4
Сүхбаатар	16	5	44	10	12
Хэнтий	6	18	5	10	40
Нийт	85	60	74	46	78

Хүснэгт 8 /нийт 342 өвлөн уламжлагч хамрагдсан/




Зураг 14 /нийт 342 өвлөн уламжлагч хамрагдсан/

1.26. Та эрүүл мэнддээ анхаардаг уу? хариултаа сонгоно уу?						1.27. Та эрүүл мэндийн үйлчилгээ тогтмол авч чаддаг уу? Хариултаа сонгоно уу?				1.28. Та эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэхэд нэг удаадаа хэдэн төгрөг зарцуулдаг вэ? Хариултаа сонгоно уу?			
Аймаг, нийслэл	Бүрэн анхаарч чаддаг	Анхаарч чаддаг	Дунд зэрэг анхаардаг	Бага зэрэг анхаардаг	Анхаардаггүй	Сард 1 удаа	Улиралд 1 удаа	Жилд 1 удаа	Авдаггүй	0-50.000 хүртэл төгрөг	51.000 - 150.000	151.000 - 200.000	201.000-төгрөгөөс дээш
Нийслэл	20	39	31	7	2	14	21	50	14	39	15	26	17
Дорнод	20	45	12	1	0	14	41	20	3	32	22	10	14
Сүхбаатар	7	38	15	13	14	13	10	36	28	46	15	7	19
Хэнтий	4	28	30	13	3	4	10	53	12	31	18	14	16
Нийт	51	150	88	34	19	45	82	159	57	148	70	57	66


Хүснэгт 9 /нийт 343 өвлөн уламжлагч хамрагдсан/

Та эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэхэд нэг удаадаа хэдэн төгрөг зарцуулдаг вэ?




Зураг 15 /нийт 341 өвлөн уламжлагч хамрагдсан/

Та эрүүл мэндийн үйлчилгээ тогтмол авч чаддаг уу?



Зураг 16 /нийт 343 өвлөн уламжлагч хамрагдсан/




Зураг 17 /нийт 343 өвлөн уламжлагч хамрагдсан/

Судалгаанд хамрагдсан хүний 13 хувь тусгай хэрэгцээт үйлчилгээ шаардлагатай гэсэн хариулт сонгосноос 32 хувь нь тулгуур эрхтэн, 27 хараа, 17 хувь нь сонсгол гэсэн нь судалгааны зорилтот бүлгийн хүрээнд насжилтаас хамааралтай тусгай хэрэгцээ байж болох магадлалтай хэдий ч СББӨ-ийн өвлөн уламжлагчдын дунд тусгай хэрэгцээ шаардлагатай бүхий хүмүүсийн судалгааг дахин нягтлан судлах шаардлагатай.



Зураг 18 /нийт 44 өвлөн уламжлагч хамрагдсан/

Та нийгмийн амьдралд чөлөөтэй оролцоход тусгай хэрэгцээний ямар нэг тохируулга шаардагддаг уу?



Зураг 19 /нийт 335 өвлөн уламжлагч хамрагдсан/

3.1. Танай дүүргийн СББӨ-ийн хадгалалт, хамгаалалтын нөхцөл байдалд байгалийн эергээр нөлөөлж буй хүчин зүйлс юу байна вэ? Хариултаа сонгоно уу?

Аймаг, нийслэл	Бэлчээрийн нөөц, даац	Өвс, ургамлын гарц	Отрын бүс нутаг	Усны нөөц	Байгалийн ашиг шимийн хүртээмж	Бусад
Нийслэл	9	7	4	10	7	40
Дорнод	11	1	0	4	61	0
Сүхбаатар	19	15	4	4	16	35
Хэнтий	1	6	0	2	15	31
Нийт	40	29	8	20	99	106

Хүснэгт 10 /нийт 302 өвлөн уламжлагч хамрагдсан/



Зураг 20 /нийт 302 өвлөн уламжлагч хамрагдсан/



Зураг 21 /нийт 215 өвлөн уламжлагч хамрагдсан/

3.2. Танай дүүргийн СББӨ-ийн хадгалалт, хамгаалалтын нөхцөл байдалд байгалийн нөлөөллийн сөрөг хүчин зүйлс юу байгаа вэ? Хариултаа сонгоно уу?

Аймаг, нийслэл	Бэлчээрийн даацын доройтол	Хөрсний доройтол	Ой хээрийн түймэр	Цөлжилт	Ган	Зуд	Үер ус	Газар хөдлөлт	Мал, амьтны гоц халдварт өвчин (мал аж ахуйн холбогдолтой өвд)	Бусад
Нийслэл	10	16	3	8	7	6	2	1	3	38
Дорнод	40	1	60	0	11	11	1	0	5	4
Сүхбаатар	37	7	5	3	6	2	1	0	7	47
Хэнтий	10	2	12	2	7	5	0	0	1	39
Нийт	97	26	80	13	31	24	4	1	16	128

Хүснэгт 11 /нийт404 өвлөн уламжлагч хамрагдсан/

СББӨ-ийн хамгаалалтад нөлөөлж буй байгалийн эерэг хүчин зүйлс 33 хувь байгалийн ашиг шимийн хүртээмж, 13 хувь бэлчээрийн даац, 35 хувь нь бусад хэмээн дурдсан бол сөрөг хүчин зүйлсэд 37хувь ой, хээрийн түймэр, 14 хувь ган, 12 хувь хөрсний доройтол, 11хувь зуд, 8 хувь мал, амьтны гоц халдварт өвчин, 6 хувь цөлжилт зэргийг цохон тэмдэглэсэн байна.

3.4. Танай дүүргийн СББӨ-ийн хадгалалт, хамгаалалтын нөхцөл байдалд нийгмийн нөлөөллийн сөрөг хүчин зүйлс юу байгаа вэ? Хариултаа сонгоно уу? / олон хариулт сонгож болно/

Аймаг, нийслэл	Суурьшил, хотжилт, газар олголт	Цахим хэрэглээ/буруу мэдээлэл түгээх, өвийг гуйвуулах, цахим гэмт хэрэг, гм/	Өвийн талаарх мэдлэг, ойлголт дутмаг,	Гадны соёлын нөлөөлөл	Соёлын нийлэгжилт	Техник тоног төхөөрөмжийн хэрэглээ	Соёлын өвийн үнэ цэнэ, ач холбогдол буурсан	Соёлын өвийн язгуур хэв шинж агуулга гажуудсан	Өвлөн уламжлагчийг үнэлэх нийгмийн үнэлэмж доогуур	Уул уурхайн хайгуулын нөлөөлөл	Уул уурхайн ашиглалтын нөлөөлөл	Замын нөлөөлөл, /гөмөр зам, засмал зам	Дэд бүтцийн нөлөөлөл ус, салхин цахилгаан станц гм/	Шашин, угсаатны нөлөөлөл	Тусгай, хамгаалалтын бүсийн нөлөө	Ядуурал	Улс төр	Цар тахал	Бусад
Нийслэл	11	13	35	14	2	7	28	8	17	0	1	1	1	1	0	3	3	3	17
Дорнод	4		52	2	0	0	22	3	19	0	0	0	0	0	0	0	0	0	1
Сүхбаатар	4	7	30	3	0	8	12	6	7	5	9	0	0	0	0	0	0	2	29
Хэнтий	4	5	6	6	1	3	8	2	7	4	4	1	1	1	0	1	1	0	34
Нийт	23	25	123	25	3	18	70	19	50	9	14	2	2	2	0	4	4	5	81


Хүснэгт 12 /нийт 335 өвлөн уламжлагч хамрагдсан/

СББӨ-ийн хамгаалалтад нөлөөлж буй нийгмийн нөлөөллийн эерэг хүчин зүйлс 36 хувь суурьшил, хотжилт, 33 хувь цахим хэрэглээ, 10 хувь нь соёл, угсаатны зүй, ахуйд

түшиглэсэн аялал жуулчлал, 8 хувь өвийн хувьсал шинэчлэл, 8 хувь нь технологийн шинэчлэл, 6 хувь нь бүтээлч үйлдвэрлэл, хэмээн дурдсан бол сөрөг хүчин зүйлсэд 27 хувь СББӨ-ийн талаарх мэдлэг, ойлголт дутмаг байдал, 16 хувь СББӨ-ийн үнэ цэн, ач холбогдол буурсан, 16 хувь СББӨ-ийн язгуур хэв шинж, агуулга гажуудсан, 11 хувь өвлөн уламжлагч нарын нийгмийн үнэлэмж доогуур, 6 хувь гаднын соёлын нөлөөлөл, 6 хувь цахим хэрэглээ, буруу мэдээлэл түгээх, гуйвуулах, 6 хувь нь суурьшил, хотжилт, газар олголт зэргийг цохон тэмдэглэсэн байна.



Зураг 22 /нийт 335 өвлөн уламжлагч хамрагдсан/



Зураг 23 /нийт 335 өвлөн уламжлагч хамрагдсан/

3.5. Таны орлогын эх үүсвэр юу вэ? Хариултаа сонгоно уу? /Олон хариулт сонгож болно/								3.6. Таны өвлөсөн өв өрхийн эдийн засаг, санхүүд хэрхэн нөлөөлдөг вэ? Хариултаа сонгоно уу?				3.7. Таны амьдарч буй дүүрэгт СББӨ-ийг эдийн засгийн эргэлтэд оруулах эрэлт хэрэгцээ байна уу? Хариултаа сонгоно уу?			
Аймаг, нийслэл	Цалин	Тэтгэвэр /тэтгэмж/	Халамж	Малын ашиг, орлого	Ахуй, соёлын бүтээгдэхүүн	Өвөөс хүртсэн ашиг, орлого	Бусад	Маш хангалттай	Хангалттай	Нөлөө багатай	Нөлөөлдөггүй	Эрэлт байгаа	Эрэлт байхгүй	Бага зэрэг	Мэдэхгүй
Нийслэл	18	65	0	9	8	5	8	4	23	29	43	54	6	8	31
Дорнод	19	42	0	22	1	3	5	5	34	10	29	73	3	0	2
Сүхбаатар	14	40	3	23	2	13	7	3	23	16	45	54	6	11	16
Хэнтий	16	39	1	15	1	12	6	1	18	14	46	73	2	3	1
Нийт	67	186	4	69	12	33	26	13	98	69	163	254	17	22	50

Хүснэгт 13 /нийт 335 өвлөн уламжлагч хамрагдсан/




Зураг 24 /нийт 343 өвлөн уламжлагч хамрагдсан/

СББӨ-ийн өвлөн уламжлагч нарын өрхийн эдийн засгийн нөхцөл байдлын судалгаагаар 36 хувь тэтгэвэр, 14 хувь малын ашиг орлого, 13 хувь ахуй, соёлын бүтээгдэхүүн, 5 хувь өвөөс хүртсэн ашиг орлого, 28 хувь нь бусад хэмээн хариулсан.




Зураг 25 /нийт 343 өвлөн уламжлагч хамрагдсан/



Зураг 26 /нийт 171 өвлөн уламжлагч хамрагдсан/

Өвлөсөн өв нь өрхийн эдийн засаг, санхүүд хэрхэн нөлөөлдөг тухайд маш хангалттай 4 хувь, 29 хувь хангалттай нөлөөтэй, 20 хувь нөлөө багатай, 47 хувь огт нөлөөлдөггүй гэсэн

хариулт өгсөн нь өвлөн уламжлагч нарт өөрийн өвийг эргэлтэд оруулах таатай нөхцөл боломж, хөшүүрэг хэрэгтэй байгааг илэрхийлж байна. Нөлөөтэй хэмээн хариулсан нь өвийн төрлөөс хамаарч байна. Хурдан морины уяа сойлго, Дархан урлал, модон сийлбэр, арьс шир суран эдлэл, эсгий ширмэл эдлэл, мал маллах арга ухаанаас голдуу эдийн засаг санхүүд нөлөөтэй гэсэн болон бусад аман илэрхийлэл ардын язгуур урлаг уламжлалт мэдлэг ухаантай холбоотой СББӨ –ийн өвлөн уламжлагч нарын хувьд нөлөө багатай байна. Мөн судалгаанд оролцсон өвлөн уламжлагч нараас тухайн орон нутагт СББӨ-ийн эрэлт хэрэгцээ, эдийн засгийн эргэлт буй эсэхэд дийлэнх олонх нь буюу 74 хувь нь эрэлт байна хэмээн хариулсан нь эрэлт хэрэгцээ, эдийн засгийн эргэлтийг дахин нягтлан судлах, чиглэсэн бодлого шаардлагатайг илэрхийлж байна.



Зураг 27 /нийт 342 өвлөн уламжлагч хамрагдсан/

2.12. Та угийн бичиг хөтөлдөг үү? Хариултаа сонгоно уу?			2.13. Хэрэв ТИЙМ бол дараах асуултад хариулна уу? Та хэд дэх үеийнхээ угийн бичгийг хөтөлж байна вэ? Хариултаа сонгоно уу?			2.14. Таны хөтөлж буй угийн бичиг аль хэлбэрт хамаарах вэ? Хариултаа сонгоно уу?				
Аймаг, нийслэл	Тийм	Үгүй	1-3 үе	4-7 үе	8 ба түүнээс дээш	Тойрог	Цацраг	Мод	Шугам	Бусад
Нийслэл	37	62	21	13	5	4	3	11	9	13
Дорнод	30	48	6	20	5		1	5	24	
Сүхбаатар	29	58	22	9	1	5	1	2	9	14
Хэнтий	30	48	6	19	3	3	1	5	8	10
Нийт	126	216	55	61	14	12	6	23	50	37

Хүснэгт 14 /нийт 335 өвлөн уламжлагч хамрагдсан/

.15. Угийн бичиг хөтлөх уламжлалт мэдлэгийг та хэнээс сурсан бэ? Хариултыг кириллээр бичнэ үү.						2.16. Танд уламжлалт аргаар хөтөлж ирсэн угийн бичиг байдаг уу? Хариултаа сонгоно уу?		2.17. Та угийн бичиг хөтлөх уламжлалт мэдлэг, арга ухаанаа өвлүүлэн уламжлуулдаг уу? Хариултаа сонгоно уу?		2.18. Хэрэв ТИЙМ бол угийн бичиг хөтлөх уламжлалт мэдлэгийг хэнд өвлүүлэн уламжлуулж байна вэ? Хариултаа сонгоно уу?		
Аймаг, нийслэл	Өөрийн ойрын гэр бүлээс	Төрөл садан, хамаатнаас	Бие дааж	ЗГТ-р сургалтаар	Сургалтаар	Тийм	Үгүй	Тийм	Үгүй	Зөвхөн төрөл садандаа заадаг	Сурахыг хүссэн хүн бүрд зааж сургадаг	Сургалт явуулдаг
Нийслэл	13	3	9	3	8	20	31	26	18	27	8	3
Дорнод	5	3	3	3	2	7	46	16	28	12	2	1
Сүхбаатар	9	2	6	9	3	20	59	20	45	18	2	1
Хэнтий	5	1	7	5	2	8	29	12	6	13		1
Нийт	32	9	25	20	15	55	165	74	97	70	12	6

Хүснэгт 15 / нийт 101,220,171,88 өвлөн уламжлагч хамрагдсан/

1.3. СББӨ-ийн ай, өвийн төрлүүдэд хийсэн судалгаа

СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН ҮЗЛЭГ, БУСЧИЛСЭН СУДАЛГААНЫ АЖЛЫН 7 АЙ САВЫН АНГИЛАЛ											
АЙ САВ	ӨВИЙН ТӨРӨЛ					Дорнод	Сүхбаатар	Хэнтий	Улаанбаатар	Нийт	
	Соёлын биет бус өвийн Төлөөллийн үндэсний бүртгэл										
1. ЭХ ХЭЛ, АМАН УЛАМЖЛАЛ, ИЛЭРХИЙЛЛҮҮД Соёлын биет бус өвийн төлөөллийн үндэсний бүртгэл											
1. ЭХ ХЭЛ, АМАН УЛАМЖЛАЛ, ИЛЭРХИЙЛЛҮҮД	1	Бөө мөргөлийн холбоотой аман илэрхийлэл					1			0	1
	2	Буриад аман аялгуу					1				1
	3	Бэлэг дэмбэрлийн үгс						1			1
	4	Домог					1				1
	5	Дом					1	1	3		5
	6	Ерөөл					1	2	3	2	8
	7	Зүйр цэцэн үг							1		1
	8	Магтаал					1			3	4
	9	Үе удам, овог төрлийн нэршил, үг					1				1
	10	Хууч яриа					5		2		7
	11	Хэлц, хэвшмэл үг						1		2	3
	12	Үлгэр						1			1
	13	Цол дуудлага					6		3	2	11
	14	Торгууд аман аялгуу					0			2	2
	15	Түргэн хэллэг					0			1	1

	Нийт өвлөн уламжлагчийн тоо	18	6	12	12	48
	Нийт өвийн тоо	9	5	5	6	25
Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэл						
1	Хамниган аман аялгуу			2		2
2	Дарьганга аман аялгуу		2			2
3	Халх тууль	0		2	0	2
	Нийт өвлөн уламжлагчийн тоо	0	2	4	0	6
	Нийт өвийн тоо	0	1	2	0	3
	юнеско					
1	Монгол уран бичлэг	1			4	5
	Нийт өвлөн уламжлагчийн тоо	1			4	5
	Нийт өвийн тоо	1	0	0	1	2
2. АРДЫН ЯЗГУУР УРЛАГ						
Соёлын биет бус өвийн төлөөллийн үндэсний бүртгэл						
1	Барга богино дуу	1			0	1
2	Бөөгийн ая дан	1				1
3	Буриад богино дуу	4		3		7
4	Буриад-Барга уртын дуу	2				2
5	Бүүвэйн дуу	2	1			3
6	Дарьганга богино дуу		2			2
7	Лимбэ хөгжим тоглох урлаг		1		1	2
8	Урианхай богино дуу				1	1
9	Үзэмчин богино дуу	1	1			2
10	Үзэмчин-Дарьганга уртын дуу	1	2			3
11	Халх богино дуу	1	1	1	2	5
12	Халх уртын дуу	8	1	1	4	14
13	Харилцаа дуу	1	1			2
14	Хурдан морины хүүхдийн гийнгоо, марзай	1	1	1		3
15	Хуучир хөгжим тоглох урлаг	1	1			2
16	Хулсан хуур хөгжим тоглох урлаг	1				1
17	Цохилуур хөгжим тоглох урлаг	1	1		3	5
18	Шударга хөгжим тоглох урлаг	0	2	1		3
19	Ятга хөгжим тоглох урлаг	0	1			1
	Нийт өвлөн уламжлагчийн тоо	26	16	7	11	60
	Нийт өвийн тоо	14	13	5	5	37
Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэл						
1	Захчин бий биелгээ	0		0	1	1
2	Лимбэ хөгжмийг битүү амьсгаагаар тоглох урлаг	0		1	1	2
3	Уран нугаралт	0		1		1
4	Торгууд бие биелгээ				1	1
5	Халх бие биелгээ				1	1
6	Халх бүжиг	0		1		1
	Нийт өвлөн уламжлагчийн тоо	0	0	3	4	7
	Нийт өвийн тоо	0	0	3	4	7

2. АРДЫН ЯЗГУУР УРЛАГ

		Юнескогийн соёлын биет бус өв					
	1	Монгол хөөмийн уламжлалт урлаг	1			1	2
	2	Монгол ардын уртын дуу			2		2
	3	Морин хуур хөгжмийн уламжлалт урлаг	3	6	2		11
	4	Монгол бий биелгээ, уламжлалт бүжгийн урлаг			1		1
	Нийт өвлөн уламжлагчийн тоо		4	6	5	1	16
Нийт өвийн тоо		2	1	3	1	7	
3. УЛАМЖЛАЛТ БАЯР НААДАМ, ЗАН ҮЙЛ, ЁС, ТОГЛООМ НААДГАЙ, УРИА ДУУДЛАГА	3. УЛАМЖЛАЛТ БАЯР НААДАМ, ЗАН ҮЙЛ, ЁС, ТОГЛООМ НААДГАЙ, УРИА ДУУДЛАГА Соёлын биет бус өвийн төлөөллийн үндэсний бүртгэл						
	1	Дэмбээ			2	0	2
	2	Мал аж ахуйн холбогдолтой уриа дуудлага	1			0	1
	3	Мал сэтэрлэх зан үйл			1		1
	4	Монгол бөх			1		1
	5	Монгол нүүдлийн зан үйл	1				1
	6	Монгол шатар				1	1
	7	Үндэсний сур харваа	2			1	3
	8	Хөлөгт ба өрөгт тоглоомын уламжлалт төрлүүд	1	1			2
	9	Хурдан морины уралдаан	1				1
	10	Хүүхэдтэй холбоотой ёс, зан үйл, найр	2				2
	11	Цаасан болон модон тоглоомын уламжлалт төрлүүд	1				1
	12	Үгэн тоглоомын уламжлалт төрлүүд	1				1
	13	Шагайгаар тоглох, наадах	1		1	1	3
	Нийт өвлөн уламжлагчийн тоо		11	1	5	3	20
	Нийт өвийн тоо		9	1	4	3	17
	Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэл						
	1	Төл авхуулах ая дуудлага, зан үйл	1	1		1	3
	2	Уул овоо тахих монгол зан үйл	2		1		3
	3	Халх хуримын ёс, зан үйл				1	1
	4	Боржигин хуримын ёс, зан үйл			1		1
	5	Буриад хуримын ёс, зан үйл	2				2
6	Язгуур шүтлэгийн ёс, зан үйл	1				1	
Нийт өвлөн уламжлагчийн тоо		6	1	2	2	11	
Нийт өвийн тоо		4	1	2	2	9	
Юнескогийн соёлын биет бус өв							
1	Шагайн харваа	2	1	7	6	16	
Нийт өвлөн уламжлагчийн тоо		2	1	7	6	16	
Нийт өвийн тоо		1	1	1	1	4	
4. БАЙГАЛИЙН БОЛОН САВ ШИМ ЕРТӨНЦИЙН ТУХАЙ МЭДЛЭГ, ЗАН ҮЙЛ	4. БАЙГАЛИЙН БОЛОН САВ ШИМ ЕРТӨНЦИЙН ТУХАЙ МЭДЛЭГ, ЗАН ҮЙЛ Соёлын биет бус өвийн төлөөллийн үндэсний бүртгэл						
	1	Байгаль хамгаалах уламжлалт арга мэдлэг, зан үйл		1			1
	2	Монгол зурхай		1		2	3
	3	Хурдан морь сойх, уралдуулах мэдлэг	1	2	2	2	7
	4	Хурдан морь шинжих мэдлэг			1		1
	5	Чулуу татах мэргэ	1		1		2

	Нийт өвлөн уламжлагчийн тоо	2	4	4	4	14	
	Нийт өвийн тоо	2	3	3	2	10	
Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэл							
1	Тэнгэр, эрхэс, цаг агаар шинжих уламжлалт мэдлэг	1	1	2	0	4	
	Нийт өвлөн уламжлагчийн тоо	1	1	2	0	4	
	Нийт өвийн тоо	1	1	1	0	3	
УЛАМЖЛАЛТ АРГА УХААН	5. УЛАМЖЛАЛТ АРГА УХААН						
	Соёлын биет бус өвийн төлөөллийн үндэсний бүртгэл						
	1	Ардын сурган хүмүүжүүлэх ухаан		1		0	1
	2	Арьс, шир боловсруулах уламжлалт арга	2	2	5		9
	3	Бариа заслын аргаар анагаах арга ухаан	3		5	3	11
	4	Дом, шившлэгийн аргаар анагаах арга ухаан	1		1		2
	5	Каз хийх арга			2	1	3
	6	Мал хатгах уламжлалт мэдлэг	2	4	3		9
	7	Мал ханах уламжлалт мэдлэг	1				1
	8	Монгол үндэсний уламжлалт, цай ундаа хийх арга	3	2			5
	9	Ноос, ноолуур боловсруулах уламжлалт арга	1		3		4
	10	Угийн бичиг хөтлөх монгол уламжлалт мэдлэг	1		1	15	17
	11	Ургамлын зүйлээр анагаах арга ухаан	2	2			4
	12	Монголын уламжлалт уях зангидах урлал		1			1
	13	Цагаан идээ бэлтгэх уламжлалт арга	1	1	1	3	6
		Нийт өвлөн уламжлагчийн тоо	17	13	21	22	73
		Нийт өвийн тоо	10	7	8	4	29
	Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэл						
	1	Нохойгоор ан хийх, сургах			3	0	3
	Нийт өвлөн уламжлагчийн тоо	0	0	3	0	3	
	Нийт өвийн тоо	0	0	1	0	1	
МАЛ МАЛЛАХ АРГА УХААН	6. МАЛ МАЛЛАХ АРГА УХААН						
	Соёлын биет бус өвийн төлөөллийн үндэсний бүртгэл						
	1	Адуун сүрэг маллах арга ухаан		1	2	0	3
	2	Тэмээн сүрэг маллах арга ухаан		1			1
	3	Үхэр сүрэг маллах арга ухаан		3			3
	4	Ямаан сүрэг маллах арга ухаан		1			1
	5	Хонин сүрэг маллах арга ухаан	1		2		3
	Нийт өвлөн уламжлагчийн тоо	1	6	4	0	11	
	Нийт өвийн тоо	1	4	2	0	7	
УЛАМЖЛАЛТ ГАР УРЛАЛ	7. УЛАМЖЛАЛТ ГАР УРЛАЛ						
	Соёлын биет бус өвийн төлөөллийн үндэсний бүртгэл						
	1	Баримлын урлал	1			0	1
	2	Бөөгийн хувцас урлал	1				1
	3	Бөхийн зодог шуудаг урлал			1		1
	4	Буриад нум сум урлал				1	1
	5	Буриад хувцасны уламжлалт урлал	1			1	2
6	Зээгт наамлын уламжлалт урлал	1			1	2	

7	Модон сийлбэрийн урлал	1	3	3		7
8	Монгол гутлын урлал			2	1	3
10	Монгол дархны уламжлалт арга ухаан	3	5	2	5	15
11	Монгол зургийн урлал		3		3	6
12	Монгол эмээл хийх урлал			1		1
13	Монголын уламжлалт арьс ширэн эдлэлийн урлал	2	2	2	3	9
14	1. Монголын уламжлалт уях зангидах урлал			1		1
15	Монголын уламжлалт модон эдлэлийн урлал	2	1		5	8
16	Монгол малгайн урлал			2		2
17	Уламжлалт нэхэх, сүлжих урлал				2	2
18	Уламжлалт уран хатгамал, оёдлын урлал			4	3	7
19	Үйсэн урлал	1				1
20	Үндэсний нум сум урлал	1			1	2
21	Халх хувцасны уламжлалт урлал	2	3	3	3	11
22	Ходок тэрэг хийх уламжлалт арга	1				1
23	Хөөрөг урлал			1		1
24	Шуумлын урлал	1		1		2
25	Эсгий ширмэл урлал	1	5	3	1	10
Нийт өвлөн уламжлагчийн тоо		19	22	26	30	97
Нийт өвийн тоо		14	7	14	13	48
Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэл						
1	Ном бүтээх уламжлалт урлал				1	1
Нийт өвлөн уламжлагчийн тоо		0			1	1
Нийт өвийн тоо		0	0	0	1	1
Юнескогийн соёлын биет бус өв						
1	Монгол гэрийн уламжлалт урлал	2		1		3
Нийт өвлөн уламжлагчийн тоо		2	0	1	0	3
Нийт өвийн тоо		1	0	1	0	2

Хүснэгт 1

СУДАЛГААНД ХАМРАГДСАН БҮС		1. ЭХ ХЭЛ, АМАН УЛАМЖЛАЛ ИЛЭРХИЙЛ ЛҮҮД			2. АРДЫН ЯЗГУУР УРЛАГ			3. УЛАМЖЛА ЛТ БАЯР НААДАМ, ЗАН ҮЙЛ, ЁС, ТОГЛООМ НААДГАЙ, УРИА ДУУДЛАГА			4. БАЙГАЛИЙН БОЛОН САВ ШИМ ЕРТӨНЦИЙ Н ТУХАЙ МЭДЛЭГ, ЗАН ҮЙЛ			5. УЛАМЖЛАЛ Т АРГА УХААН			6. МАЛ МАЛЛАХ АРГА УХААН			7. УЛАМЖЛАЛ Т ГАР УРЛАЛ			НИЙ Т
		төлөөлөл	яаралтай	юнеско	төлөөлөл	яаралтай	юнеско	төлөөлөл	яаралтай	юнеско	төлөөлөл	яаралтай	юнеско	төлөөлөл	яаралтай	юнеско	төлөөлөл	яаралтай	юнеско	төлөөлөл	яаралтай	юнеско	НИЙ Т
ДОРНОД	Нийт өвлөн уламжл агчийн тоо	18	0	1	26	0	4	11	6	2	2	1	17	0		1			19		2	110	
	Нийт өвийн тоо	9	0	1	14	0	2	9	4	1	2	1	10	0		1			14		1	69	
СҮХБАА ТАР	Нийт өвлөн уламжл агчийн тоо	6	2	0	16	0	6	1	1	1	4	1	13	0		6			22			79	
	Нийт өвийн тоо	5	1	0	13	0	1	1	1	1	3	1	7	0		4			7			45	
ХЭНТИЙ	Нийт өвлөн уламжл агчийн тоо	12	4		7	3	5	5	2	7	4	2	21	3		4			26		1	106	
	Нийт өвийн тоо	5	2		5	3	3	4	2	1	3	1	8	1		2			14		1	55	
УЛААНБ ААТАР	Нийт өвлөн уламжл агчийн тоо	12	0	4	14	4	1	3	2	6	4		22	0		0			30	1		100	
	Нийт өвийн тоо	6	0	1	5	4	1	3	2	1	2		4	0		0			13	1		43	
НИЙТ	Нийт өвлөн уламжл агчийн тоо	48	6	5	60	7	6	20	11	6	14	4	73	3	0	11	0	0	97	1	3	395	
	Нийт өвийн тоо	25	3	2	37	7	7	17	9	4	10	3	29	1	0	7	0	0	48	1	2	212	

Хүснэгт 2

ХОЁР. ЗҮҮН БҮС БОЛОН НИЙСЛЭЛИЙН СББӨ-ИЙН УЛСЫН ҮЗЛЭГ, СУДАЛГААНЫ НЭГДСЭН ДҮГНЭЛТ

2.1.Зүүн бүс болон нийслэлийн СББӨ-ийн улсын үзлэг, судалгааны дүгнэлт

Судалгааны багийн ахлагч нар урьдчилсан дүгнэлт гаргасныг энэхүү тайланд аймаг болон нийслэл тус бүрээр танилцуулав. Үүнд:

Хэнтий аймаг:

Хэнтий аймагт СББӨ-ийн 7 айн 56 төрлийг бүртгэн баримтжуулсан бөгөөд гар урлалын ай давамгайлж байна. Энэ аймгийн СББӨ-ийн онцлог морины соёл, түүнийг дагалдсан морь шинжих, уях сойх, суран эдлэл хөгжих болжээ. Сүүлийн үед шагайн харваа, хавчаахай нумыг өндөр настнууд бүлэг болон харвах болсон, мөн тайган нохойн соёл дэлгэрч, залуус ихэд сонирхож байгаа нь ажиглагдлаа.

Гар урлалын зүйлээс үндэсний дээл хувцас, малгайн урлал голлож байгаа нь өвлөгчдийн хүйстэй холбоотой байж болно. Харин чулуу, модон сийлбэр цөөн боловч чанартай өв байх бөгөөд байгалийн нөөц баялагт тулгуурлажээ. Бэрх, Бор-Өндөрт жоншны уурхайтай учраас жонш чулуугаар бэлэг дурсгалын зүйл урладаг 2 өвлөгчтэй тааралдав.

Эх хэл, аман уламжлал, илэрхийллийн айд халх туулийн голомт ховор боловч байгааг нь олж тодруулсан нь судалгааны багийн олз гэж хэлж болно. Харин бусад төрөл мартагдах шинжтэй болсныг зориуд тэмдэглэж байна. Тиймээс аман соёлын өвийг түлхүү анхаарч язгуур урлагтай холилдуулалгүй хөгжүүлэх шаардлага тулгарчээ. Мөн хамниган аялгуу үндсэндээ мөхөж байгааг анхаарч яаралтай баримтжуулалт хийх, толь бичиг болтугай авч үлдэх ёстой болжээ.

Өв өвлөн уламжлагдах байдлыг судалгаанаас харахад 1 дэх үедээ өвлөн уламжлагчид олон бол 3 дахь үедээ өвлөн уламжлагчид хамгийн цөөн буюу 13 хувьтай байгаад бид анхаарлаа хандуулах шаардлагатайг харуулж байна.

Өв өвлөн уламжлагдах байдлын хувьд ахуй амьдралаасаа сурч мэдсэн нь 73,8%, албан бус сургалтаар 6,2% байгаа нь Хэнтий нутгийн өв харьцангуй язгуур чанараа алдаагүй байгаа хэрэг юм. Энэ нь өвлөн уламжилсан хэлбэрүүдийн үзүүлэлтээр баталгаажиж байгаа бөгөөд өвлөн уламжлагчийн 55% нь гэр бүл, 11% нь төрөл садангаасаа сурчээ. Тиймээс соёлын өвийг уламжлан хадгалах цаашдын хандлагыг энэ чиглэлд илүү анхаарах нь зүйтэй.

Хэнтий аймгийн 16 сум, 3 тосгонд ажиллаж нийт 106 өвлөн уламжлагчтай уулзаж бүртгэлтэй 79 хүнийг цахим бүртгэлд хамруулсан. Мөн Биндэр, Батширээт, Баянхутаг суманд хамниган аялгуу, өвийн талаар мэддэг настайчуудыг сураглаж 4 хүнтэй уулзсан бөгөөд бүртгэлд хамрагдаагүй энэ мэт хүмүүс байв.

Нийт өвлөн уламжлагчийн хүйсийн байдал эмэгтэй давамгай буюу 51%, насны хувьд тэтгэврийн хүмүүс (79 хүний 37 нь) эзэлж байна. Магадгүй бид настайчуудтай эхэлж уулзах гэдэг сонирхол давамгай байж болох ч ерөнхийдөө өвлөн уламжлагчид буюу уламжлалаа мэддэг, өвийн зүйлээ хадгалж хийж байгаа хүмүүс бол өндөр насны тэтгэвэртээ гарсан, эмэгтэйчүүд голлож байсан. Тэдний идэвх оролцоо ч сайн, Соёлын Төвөөс зохиодог аливаа соёл, урлагийн арга хэмжээнд голлон идэвх санаачлагтай оролцдог болохыг соёлын байгууллагын ажилтнууд дурдаж байсан.

УНБМСанд анхан шатны бүртгэлээр бүртгэгдсэн өвлөн уламжлагчийн шалгуурыг хангаагүй болон өөрийн хүсэлтээр бүртгэлээс хасалт хийлгэх саналыг үзлэгийн багт уламжилж байсан. Мөн бүртгэлийн мэдээлэлд шилжилт хөдөлгөөний тэмдэглэлийг цаг тухайд нь хийгээгүйн улмаас тоон дүн зөрөх, давхардах зэрэг бүртгэлийн нийтлэг алдаа гарсаар байна. Үзлэгээр 28 өвлөн уламжлагчийг шинээр тодруулав.

Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт СББӨ-ийн талаар 3-4 зүйл тусгагдсан ажлын нэг хэсэг нь СББӨ-ийн бүртгэлийг цахимжуулах ажил байсан бөгөөд энэ ажил нь нь одоог хүртэл хийгдээгүй байна. Өвлөн уламжлагчдын бүртгэлд хамрагдалтын судалгаанаас 85 орчим хувийг орон нутгийн мэргэжилтнүүд олж тодруулж байгаа нь орон нутгийн СӨ-ийн мэргэжилтний үүрэг өндөр байгааг харуулж байна. Үзлэгийн явцад мэргэжилтний мэдлэг, ур чадвар сул байгаа ажиглагдсан.

Сүхбаатар аймаг:

Сүхбаатар аймгийн СББӨ-ийн онцлох ай, өвийн төрлүүд түүхэн хөгжлийн үйл явцтай гүнзгий холбоотой юм. Одоогийн Сүхбаатар аймгийн нутагт 1697 онд Манж Чин улсын эзэн хааны зарлигаар анх адуун сүрэг байгуулсан бөгөөд одоо ч Сүхбаатар аймаг нь хурдан угшлын адуу ихтэй, улс, аймаг, бүсийн хэмжээний уралдаанд Сүхбаатарын угшилтай адуу үзүүр түрүүнд хурдалдаг нутаг билээ. Мөн Дарьганга хошуу эртнээс дархан урлалаар алдартай байсан нутаг билээ.

- Уламжлалт гар урлал үүнд Дарьганга дархан урлал, Сүхбаатар аймаг мод багатай газар хэдий ч модон сийлбэр урлал, эсгий ширмэл урлал голлож байна.
- Мал маллах уламжлалт арга ухаан ай дотор Адууны соёл Сүхбаатар аймагт өргөн дэлгэр тархсан.
- Ардын язгуур урлагийн ай сав дотор Морин хуур хөгжим урлал, морин хуурын татлага, Уртын дуу зэрэг онцлох өвийн төрлүүд байна.

Сүхбаатар аймгийн СББӨ-д хийсэн цахим судалгааны тоон болон аналитик үзүүлэлт нэгтгэн дүгнэлт хийвэл Халх угсаатан 44 хүн Дарьганга угсаатан 39 хүн Үзэмчин 4 хүн хамрагдаж угсаатны бүлэг хамрагдаж бусад угсаатны бүлгээс 2 хүн хамрагдсан байна, Мөн үзлэг судалгаанд хамрагдсан өвлөн уламжлагч нарын 96 хувь нь аймгийн уугуул, 75 хувь нь сумын уугуул иргэд байна. Насны бүтцийн хувь 60-80 насны иргэд хамгийн олон буюу 30 хувь эзэлж байна. Мөн 46-60 насны 25 дээш хувь, 36-45 хувь нь 10 гаруй хувь, харин 80-аас дээш насны хүн хамгийн бага 7 хувь байна.

Ажил мэргэжлийн хувьд 23 хувь нь малчин иргэд бөгөөд 43 хувь нь тэтгэврийн насны иргэд, дөнгөж 16 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч бөгөөд өвлөн уламжлагч нарын орлогын эх үүсвэр нь цалин тэтгэвэр малаас хүртсэн ашиг шим давамгайл байна. Ийм учир төрөөс СББӨ-ийн өвлөн уламжлагч нарт төрөөс тодорхой дэмжлэг шаардлагатай.

СББӨ-ийг орон нутагтаа эдийн засгийн эрэлтэд оруулах шаардлагатай хэмээн хариулжээ. СББӨ-ийн өвлөн уламжлагч нар дундаа ардын язгуур урлагтай холбоотой өвлөн уламжлагч нар нь өвөөс хүртэх ашиг орлого гэх зүйл байхгүй бөгөөд цаашид эдгээр өвлөн уламжлагч нартаа тодорхой дэмжлэг үзүүлэх шаардлагатай. Мөн судалгаанд хамрагдсан өвлөн уламжлагч нарын 68 хувь нь угийн бичиг хөтөлдөггүй хэмээн хариулсан бөгөөд энэ нь Сүхбаатар аймгийн угсаатны бүлгийн түүхэн бүрдэлтэй холбоотой байж болно.

СББӨ-ийн тогтвортой байдал хойч үедээ уламжлуулах байдал нь 68 хувь нь эцэг эх гэр бүлийн хүрээнд өвлөн уламжилсан ба 2-3 дах үеийн өвлөн уламжлагч нарын 56 хувь 3 –аас дээш үеийн өвлөн уламжлагч 15 хувь байна. Дархан урлал уран дарханаас бусад өвийн хүрээнд өвлөн уламжлуулах үйл явц харьцангуй тогтвортой байна.

Орон нутгийн хэмжээнд өвлөн уламжлагч нарыг эдийн засаг санхүүгийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх соёлын бүтээлч үйлдвэрлэл нэвтрүүлэх, Өвийн төрөл бүтээгдэхүүн үйлдвэрлэж өрхийн

орлого нэмэгдүүлэх зорилгоор хэрэгжүүлсэн хөтөлбөрүүд олон бөгөөд үүнд голцуу уламжлалт цагаан идээ боловсруулах арга ухаан, эсгийн хийх, эсгий ширмэл урлал, суран эдлэл, модон эдлэл зэрэг төрлүүд голчлон хамрагдсан байна.

Хурдан морины соёл сайн хадгалагдан үлдсэн нь эдийн засгийн эргэлт сайтай орон нутаг нь өөрөө /Сүхбаатарын хурдан угшлын адуу нь/ зах зээлд брэнд болж чадсантай холбоотой.

Сүхбаатар аймгийн соёл урлагийн газар идэвх хичээл зүтгэл сайтай залуу боловсон хүчнээс бүрдсэн хамт олон бөгөөд хээрийн судалгааны 22 хоногийн турш харилцаа холбоо сайтай байж очсон сум бүр дээр СББӨ-ийн өвлөн уламжлагч нартаа холбох уулзуулах ажлыг сайн зохион байгуулсан хэмээн дүгнэж байна.

Дорнод аймаг:

Бид тоон болон чанарын судалгааны арга зүйгээр цуглуулсан эх хэрэглэгдэхүүнд тулгуурлан Монголчуудыг Монголоор нь байлгаж буй соёлын аргамж нь соёлын биет бус өв, түүнийг өвлөн уламжлагчид хэмээн үзэж байна.

Дорнод аймаг бол Монгол улсын зүүн хязгаарт орших Халх, Буриад, Үзэмчин угсаатны бүлгээс бүрдсэн аймаг юм. Байгалийн тогтцын хувьд хойд хэсгээрээ ойт хээр, хээрийн бүс, дунд болон өмнөд, зүүн, баруун хэсгээрээ тал хээрийн бүст оршдог. Энэ утгаараа тал нутагт тайван амгалан аж төрж байна. Дорнод аймгийн хэд хэдэн сум, Сангийн аж ахуй түшиглэн байгуулагдсан тул Монгол улсын өнцөг булан бүрээс цугласан хүн амаас бүрддэг. Энэ нэг талаараа олон соёлын нийлэгжил бий болгох үндэс болсон байна. Өөрөөр хэлбэл, Дорнод аймагт орших соёлын аргамжны орон зайд Монгол Улсын олон угсаатны бүлгийн онцлог байхаас гадна хил залгаа БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Барга, Үзэмчин, Буриад угсаатны бүлэг, ОХУ-ын БН Буриад улсын Буриад Монголчууд соёлын хувьд нягт харилцаатай байна. Энэ нь Дорнод аймгийн соёлын биет бус өвийн орон зайг тодорхойлоход чухал хүчин зүйл болж байна. Энэ бидний соёлын аргамжны орон зайд тэдний хувь нэмэр чухал нөлөө үзүүлж байгааг бид угсаатны бүлэг ба түүнд тулгуурласан соёлын наадмуудын хүрээнд авч үзсэн билээ. Бидний дорнод аймгийн соёлын аргамжийг бөхөлж буй нэг хүчин зүйл нь угсаатны бүлэгт тулгуурласан соёлын наадам хэмээн үзэж байна.

Дорнод аймгийн хувьд соёлын биет бус өв өвлөн уламжлагчийн өнөөгийн байдал гундуу байна. Тухайлбал, зарим өвлөн уламжлагч нар амьдралын боломж муу, амьдралын шаардлагаар өөр зүйл хийж, мэдлэг, уламжлалаа залуучуудад өвлүүлэх, түгээн таниулах тал дээр цалгардаж байна. Нөгөө талаараа тэднийг үнэлэх нийгмийн үнэлэмж доогуур байгаа нь тус аргамж гандах үндсэн шалтгаан болж байна. Мөн хорвоогийн жамыг даган өндөр настай өвлөн уламжлагчид тэнгэрт дэвшиж байгааг бид бодолцох шаардлага байна. Мөн бид тус соёлын аргамж болж буй өвлөн уламжлагчаа тордох, өнгөлөхөд хөрөнгө зарцуулах, дэмжиж туслах шаардлага байна.

Монголчууд мал аж ахуйн соёлтой тул гадас хэдий сайн ч аргамж муу бол морь тогтохгүй гэдгийг сайн мэднэ. Үүний нэгэн адил гадас нь муу бол аргамжаа бөхөлсний хэрэг гардаггүй. Соёлын биет бус өвийн тухайд асар үнэ, хүндтэй эрхмүүд бол ахмадууд юм. Тэднээс бид соёлын мөн чанар, уламжлалт ёс, зан үйл гэх мэт маш олон зүйлийг сурвалжлан аргамжиж авах шаардлага байна. Бид яарахгүй бол тэд хүлээхгүй. Ахмад настнуудыгаа идэвхжүүлэн залуу үедээ өвлүүлж буй сайн жишээ Дашбалбар, Баян-Уул сумдад байна. Дашбалбар суманд “Нутгийн домог”, Баян-Уул суманд “Наранбулаг” гээд ахмадын хамтлаг үр дүн өндөртэй ажиллаж байна. Гэхдээ энэ бол нэг л арга юм. Бид маш богино хугацаанд олон аргаар ахмадуудтайгаа тулж ажиллаж, сум, аймгийнхаа өв соёлыг тэмдэглэн авч үлдэх, өвлөн уламжлуулах хэрэгцээ нэн шаардлагатай байна.

Дорнод аймагт өвийн ажилтнуудыг соёлын өвийн талаарх мэргэжил арга зүйгээр хангаж, тэдний ажлын нөхцөлд анхаарлаа хандуулах, тоног төхөөрөмжөөр хангах зайлшгүй шаардлага байна. Үндэсний хөгжимтэй сум цөөхөн байна. Дорнод аймгийн төвд Л.Идэрбат багш шавь сургалт зохион байгуулж олон хүнд уртын дуу заажээ. Тэд бэсрэг уртын дууг голчлон дуулж байна. Тэдний дууны урын сан бага, дуулах чадвар дутмаг байна. Сургалтыг цаашид эрчимжүүлэх шаардлагатай хэмээн үзлээ.

Дээрх санаагаа нэгтгэн дүгнэж үзвэл Дорнод аймгийн соёлын бит бус өвийн тухайд уламжлалт гар урлалын өвийн төрөл зүйлээс Буриад хувцасны уламжлалт урлал, Халх хувцасны уламжлалт урлал, Бөөгийн хувцас урлал, Монгол гэрийн уламжлалт урлал, Эсгий ширмэл урлал, Монголын уламжлалт модон эдлэлийн урлал, эмээл хийх урлал, үйсэн урлал, модон сийлбэрийн урлал харьцангуй түгээмэл хадгалагдаж байна. Харин үндэсний нум сум урлал нь Манж Чин улсын үед Монголд дэлгэрсэн урт, том нум сумны урлал Баяндун суманд хийгдэж байна. Нум сумны урлалыг дундад зууны Монгол нум сумны хэлбэр хийц рүү чиглүүлэх шаардлагатай байна. Монгол дархны уламжлалт арга ухаан, баримлын урлал, шуумлын урлал, зээгт наамлын уламжлалт урлал, ходок тэрэг хийх уламжлалт арга ухаан харьцангуй бага аймаг сумын хэмжээнд нэг хоёр л хүнд хадгалагдаж байна.

Нутаг нутагт цагаан идээ боловсруулах, морь, бөх цоллох, арьс ширэн эдлэл, модон эдлэл, гэрийн мод урлал нь хүмүүсийн эрэлт хэрэгцээнд үндэслэн хийгддэг тул харьцангуй сайн хадгалагдан үлджээ. Харин зан үйл болон төдийлөн хийгдээд байдаггүй өв соёлууд ерөнхийдөө тасарсан маягтай байна. Үүнд, хүүхэдтэй холбогдох зан үйлүүд, байгаль шинжих арга ухаан, нүүдэл хийх уламжлалт арга зэрэг өвүүд орж байна.

Халхгол суманд Буйр нуурыг үзэхээр ирж буй дотоодын аялагчдын тоо жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа тухай нутгийнхан ярьж байна. Энэ аяллыг түшиглэн “Соёлын үйл ажиллагаа” зохион байгуулах, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх шаардлагатай байна.

Улаанбаатар хот:

Аймаг, нийслэлийн Соёлын байгууллагын ажилтан (музейн БМСанч) ажлаас гарах, дэвших зэргээр солигдож байгаатай холбоотой бүртгэл мэдээллийн сангийн хадгалалтын аюулгүй байдал маш хангалтгүй байна. (БМСангийн мэдээлэл устаж алга болох тохиолдол гарсаар байна.) Иймд БМСангийн хадгалалтын аюулгүй байдалд хяналттай байя.

Дүүргүүдийн СББӨ-ийн бүртгэлтэй танилцахад шинээр өвлөн уламжлагчийг нэмэх, хасах, шилжилт хөдөлгөөний тэмдэглэлийг огт хийгээгүй дутагдалууд байна. Цаашид СББӨ-ийн бүртгэлд шинээр өвлөгчийг таньж тогтоох, бүртгэх ажлыг тухайн аймаг, сум, дүүргийн ЗДТГ-ын дэргэдэх орон тооны бус зөвлөлөөр хэлэлцүүлэн бүртгэж авдаг байсан өмнөх тогтолцоог СББӨ-ийг бүртгэх тухай шинэчилсэн журамд тусгаж оруулах нь зүйтэй

Соёлын өвийн чиглэлээр арга хэмжээ 2022 онд огт төлөвлөөгүй, хийгээгүй дүүргүүд байна. Иймд өв, өвлөн уламжлагчийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, өвийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажлыг төлөвлөн хэрэгжилтийг нь хянах цаг нэгэнт болжээ.

СББӨ, өвлөн уламжлагчийг хамруулах түүвэр судалгааг хийхдээ засаг захиргааны онцлог байдлаас үүдэн Нийслэлийн бүсэд “Мал маллах арга ухаан” ай савыг оруулаагүй, бусад 6 ай савын хүрээнд хийсэн.

Нийслэлийн 9 дүүргээс СББӨ-ийн Төлөөллийн үндэсний бүртгэлийн 6 ай савд хамаарах 33 өв, Яаралтай хамгаалах шаардлагатай СББӨ-ийн 2 ай савд хамаарах 7 өв, ЮНЕСКО-ийн СББӨ -ийн 3 ай савд хамаарах 3 өвийг хамруулсан.

Монголын ард түмний СББӨ уламжлагчдын багагүй хэсэг нь эх орны нийслэл Улаанбаатар хотноо аж төрж байна. Иймээс Улаанбаатар хот бүхэлдээ монголын олон угсаатны соёлын өв уламжлалыг хадгалж, тээж байгаа өвөрмөц соёлын хот юм.

Малчин ардын болон хүрээ төвшний соёлын уг үндэс, язгуур угсаа урьдын бий болсон хүрээ маягийн дуу, хөгжим соёлын уламжлал нийслэл хотод байсан. Энэ уламжлал бүдгэрч ардын болон хүрээ дууны онцлог аялгуу, чамин сайхан нугалаа ая данг мэддэг хүн цөөхөн болжээ.

Судалгаагаар гар урлал, угийн бичиг, бариа засал гэсэн өвүүд бусад өвийн төрлөөс олон байгаа нь ажиглагдав. Уламжлалт гар урлалын ай сав хамаарах модон эдлэл, дарханы урлал, бариа засал, эсгий урлал зэрэг өвд хамаарах өвлөн уламжлагчид нь бие даасан урлан, цехтэй болтлоо өргөжиж өвөөрөө дамжуулан өрхийн орлогоо дээшлүүлж байна.

Энэ удаагийн үзлэгээр нийслэлийн бүх дүүргүүд зохион байгуулалтын хувьд маш хангалтгүй оролцлоо. Судалгаанд хамрагдах өвлөн уламжлагчдад судалгааны зорилго чиглэлийн талаар буруу мэдээлэл өгч ирүүлсэн нь судалгаанд хамрагдах хүмүүс гээгдэж орхигдох тал ажиглагдсан. Мөн өвлөн уламжлагчийн өвийн талаарх мэдлэг ойлголт сул байна. Нийслэлийн дүүрэг болгонд ардын язгуур урлагийн хамтлагуудтай, соёл, урлагийн арга хэмжээ болон бие даасан уран бүтээлийн тоглолт хийж өрхийн орлогоо дээшлүүлж байна. Эдгээр ахмад өвлөн уламжлагчдад төр, захиргааны байгууллагын дэмжлэг байхгүй байгааг онцлох нь зүйтэй.

2.2. Нэгдсэн дүгнэлт

1. Зүүн бүсийн 3 аймаг болон Улаанбаатар хотын судалгаанд хамрагдсан 335 өвлөн уламжлагчийн 48% нь буюу 161 хүн нь 61-80 настай өндөр настангууд байгаа нь өвлөн уламжлагчдыг амьд ахуйд нь мэдлэг, чадавхыг дүрс бичлэгээр бүртгэн баримтжуулах, шавь сургалтыг өвлүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

2. Өвлөн уламжлагчдын “Хөдөлмөр эрхлэлтийн байдлын судалгаа”-нд 49% нь буюу 164 хүн нь тэтгэвэрт, 16% нь буюу 54 хүн нь малчин, 17% буюу 58 хүн нь төрийн байгууллагад, 12% буюу 39 нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг, 5% буюу 17 нь хувийн хэвшлийн байгууллагад ажилладаг хэмээн эрэмбэлэгдсэн ба дийлэнх зонхи нь тэтгэврийн орлогоор амьдардаг байна.

3. Өвлөн уламжлагчийн бүртгэлд хамрагдалтын судалгаанаас нийт хамрагдсан 288 хүний хүний 69% буюу 199 хүнийг орон нутгийн мэргэжилтнүүд, 16% буюу 45 хүнийг судлаачид, 9% буюу 25 хүн өөрөө, 6% буюу 19 хүн нь хэн бүртгэснийг мэдэхгүй гэсэн мэдээлэл цуглагдсан нь орон нутгийн соёлын өвийн мэргэжилтний үүрэг өндөр байгааг харуулж байна.

4. Өвийг уламжлан авсан байдлын судалгаанд өөрийн ойрын гэр бүл, төрөл садан, хамаатан, шавь сургалыг зэрэг ахуй амьдралаасаа сурч мэдсэн нь 72%, гэр бүлээсээ сурсан нь 54%, бие дааж сурсан нь 20%, төрөл садангаасаа сурсан нь 9%, шавь сургалтаар 9%, танхимын сургалтаар 8%, нь сурсан нь соёлын биет бус өв харьцангуй язгуур чанараа алдаагүй байгаа хэрэг юм.

5. “Та хэд дэх үеийн өвлөн уламжлагч вэ гэдэг судалгаа”-нд 343 хүн хамрагдсанаас 38% буюу 130 хүн нь 1 дэх үеийн, 29% нь буюу 100 хүн нь 2 дахь үеийн, 20% буюу 68 хүн нь 3 дахь үеийн, 13% буюу 45 хүн нь 4 дэх үеийн хүмүүс байгааг ажиглахад 1- 2 дахь үеийн өвлөн уламжлагч нарын тоон дүн давамгайл байсан нь цаашид тухайн СББӨ нь өөрчлөлтөд орох магадлал өндөр буйг илэрхийлж

мөн СББӨ-ийн утга, агуулга гуйвах үүнээс улбаалаад ач холбогдол, үнэ цэн нь буурах эрсдэл үүсэж болзошгүй байна.

6. Судалгаанд хамрагдсан өвлөн уламжлагчдын 79% нь эзэмшиж буй өвөө тодорхой хэмжээнд өвлөн уламжлуулж байгаа бол 21% нь ямар нэг хэмжээгээр өвлүүлж уламжлуулж амжаагүй байгаа мэдээ илэрсэн нь өвийг уламжлуулах, өвлүүлэх ажлыг зохих хэмжээнд эрчимжүүлэх хэрэгтэй гэж үзлээ.

7. Харьяа засаг захиргааны нэгжээс танд дэмжлэг үзүүлдэг эсэх тухайд судалгаанд хамрагдсан 342 хүний 68% нь үгүй хэмээн хариулсан нь СББӨ-ийг хамгаалах, тогтвортой хөгжих, хөхийлэн дэмжих тал дээр сум, дүүрэг, орон нутгийн түвшинд бодлого, чиглэсэн арга хэмжээ сул буйг илэрхийлж байна. Харин “Тийм” хэмээн 9%, “Заримдаа дэмждэг” гэдэгт 18%, “Мэдэхгүй” хэмээн 5% нь тус тус хариулжээ.

8. Өвийг тогтвортой үйлдэхэд ямар дэмжлэг шаардлагатай байгаа талаарх судалгаанд мөнгөн урамшуулал хүссэн 17%, байр танхимаар хангагдах сонирхолтой 17%, төсөв санхүүгийн дэмжлэг авах хүсэлтэй 16%, материаллаг хэрэглэгдэхүүнээр хангагдах хүсэлтэй 14%, уралдаан, наадамд тогтмол оролцох сонирхолтой 12% зэргээр эрэмбэлэгдсэн өвлөн уламжлагч нарт төсөл, санхүү, урамшууллаас гадна үйл ажиллагаагаа тогтмол явуулах байр, материаллаг дэмжлэг хэрэгцээ шаардлагатай байгааг илтгэж байна.

9. Судалгаанд хамрагсдын 70% нь эрүүл мэндэд анхаарч чаддаг гэсэн нь өвлөн уламжлагч нарын насны бүтэцтэй шууд хамааралтай байх магадлалтай. Учир нь 50 орчим хувь нь 60-80 настай иргэд, 3.6 % нь 80 дээш насны тэтгэврийн иргэд учир эрүүл мэндийн байдалд анхаарал хандуулан тодорхой эрүүл мэндийн үйлчилгээг тогтмол авдаг. Мөн энэхүү үзүүлэлт нь СББӨ-ийн өвлөн уламжлагч нарын хөдөлмөр эрхлэлтийн байдлаас хамааралтай бөгөөд төрийн албан хаагч нар жил бүрийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамрагдаж буй тул эрүүл мэндийн байдлаа тодорхой хянаж чаддаг хэмээн үзэхэд хүргэсэн ба харин эрүүл мэнддээ анхаардаггүй гэсэн хариултад голдуу малчид болон хувиараа хөдөлмөр эрхэлж буй иргэд хариулсан нь анхаарал татаж байна.

10. Судалгаанд хамрагдсан 343 хүний хүний 13% нь буюу 46 хүн нь тусгай хэрэгцээт үйлчилгээ шаардлагатай гэсэн хариулт сонгосон ба үүнээс 32% нь тулгуур эрхтэн, 27% хараа, 17% нь сонсгол гэсэн нь судалгааны зорилтот бүлгийн хүрээнд насжилтаас хамааралтай тусгай хэрэгцээ байж болох магадлалтай хэдий ч СББӨ-ийг өвлөн уламжлагчдын дунд тусгай хэрэгцээ шаардлагатай бүхий хүмүүсийн судалгааг дахин нягтлан судлах шаардлагатай нь ажиглагдлаа.

11. СББӨ-ийн хамгаалалтад нөлөөлж буй байгалийн эерэг хүчин зүйлсийн судалгаанд 335 хүнээс 33% нь байгалийн ашиг шимийн хүртээмж, 13% нь бэлчээрийн даац, 35 хувь нь бусад хэмээн дурдсан бол сөрөг хүчин зүйлсэд 37% нь ой, хээрийн түймэр, 14% нь ган, 12% нь хөрсний доройтол, 11% нь зуд, 8% нь мал, амьтны гоц халдварт өвчин, 6 хувь цөлжилт зэргийг цохон тэмдэглэсэн байна.

12. СББӨ-ийн хамгаалалтад нөлөөлж буй нийгмийн нөлөөллийн эерэг хүчин зүйлсийн судалгаанд 335 хүн хамрагдсанаас 36% нь суурьшил, хотжилт, 33% нь цахим хэрэглээ, 10% нь соёл, угсаатны зүй, ахуйд түшиглэсэн аялал жуулчлал, 8% нь өвийн хувьсал шинэчлэл, 8% нь технологийн шинэчлэл, 6% нь бүтээлч үйлдвэрлэл, хэмээн дурдсан бол сөрөг хүчин зүйлсэд 27% нь СББӨ-ийн талаарх мэдлэг, ойлголт дутмаг байдал, 16% нь СББӨ-ийн үнэ цэн, ач холбогдол буурсан, 16% нь СББӨ-ийн язгуур хэв шинж, агуулга гажуудсан, 11% нь өвлөн уламжлагч нарын нийгмийн үнэлэмж доогуур, 6% нь гадны соёлын нөлөөлөл, 6% нь цахим хэрэглээ, буруу мэдээлэл түгээх, гуйвуулах, 6% нь суурьшил, хотжилт, газар олголт зэргийг дурдсан байна. Энэхүү мэдээнээс ажиглахад соёл, угсаатны зүй, ахуйд түшиглэсэн аялал жуулчлал, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн

ээрэг нөлөө хамгийн сүүлээр эрэмбэлэгдсэн байгаа нь энэ талын таатай орчин нөхцөл хомс байгааг илтгэж байна.

13. Судалгаанд хамрагдсан 171 хүнээс таны өвлөсөн өв нь өрхийн эдийн засаг, санхүүд хэрхэн нөлөөлдөг тухай судалгаанд маш хангалттай нөлөөлдөг гэдэгт 4%, хангалттай нөлөөтэй гэдэгт 29%, нөлөө багатай гэдэгт 20%, огт нөлөөлдөггүй гэдэгт 47% нь тус тус хариулт өгсөн нь өвлөн уламжлагч нарт өвийг эдийн засгийн эргэлтэд оруулах таатай нөхцөл боломж, хөшүүрэг хэрэгтэй байгааг илэрхийлж байна. Хурдан морины уяа сойлго, дархан урлал, модон сийлбэр, арьс шир суран эдлэл, эсгий ширмэл эдлэл, мал маллах арга ухаан зэрэг өвийн илэрхийлэл нь голдуу эдийн засаг санхүүд нөлөөтэй гэсэн бол бусад аман илэрхийлэл ардын язгуур урлаг, уламжлалт мэдлэг ухаантай холбоотой СББӨ-ийн өвлөн уламжлагч нарын хувьд нөлөө багатай байна. Мөн судалгаанд оролцсон өвлөн уламжлагч нараас тухайн орон нутагт СББӨ-ийн эрэлт хэрэгцээ, эдийн засгийн эргэлт буй эсэхэд дийлэнх олонх нь буюу 74% нь эрэлт байна хэмээн хариулсан нь эрэлт хэрэгцээ, эдийн засгийн эргэлтийг дахин нягтлан судлах, чиглэсэн бодлого шаардлагатайг илэрхийлж байна.

2.3. Зөвлөмж, санал

Зөвлөмж:

1. Өвлөн уламжлагч нар “Өвлөн уламжлагч”-аар бүртгүүлэх хүсэлтээ хаана, ямар хэлбэрээр гаргах талаар мэдлэг ойлголт дутмаг байгаа нь аймаг, нийслэлийн СУГ, Засаг даргын тамгын газар (мэргэжилтэн, нийгмийн ажилтан) хоорондын ажлын уялдаа дутмаг байгааг харуулж байна. Иймд байгууллага хоорондын уялдаа холбоог сайжруулах хэрэгтэй.
2. Соёлын өвийн Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан дахь Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагч нарын бүртгэл мэдээллийг аймаг, нийслэлийн Соёлын өвийн бүртгэлтэй тулгалт хийх шаардлагатай.
3. Аймаг, нийслэлийн бүртгэл мэдээллийн сангийн СББӨ-ийн бүртгэлд шинээр өвлөгчийг таньж тогтоох, бүртгэх ажлыг тухайн сум, дүүргийн ЗДТГ-ын дэргэдэх орон тооны бус зөвлөлөөр хэлэлцүүлэн бүртгэж авах ажлыг СББӨ-ийг бүртгэх шинэчилсэн журамд тусгах.
4. Аймаг, нийслэлийн СУГ, соёлын төвийн мэргэжилтэн, нийгмийн ажилтнуудыг соёлын өвийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, мэргэжлийн арга зүйгээр хангаж, чадавхыг бэхжүүлэх.
5. Орон нутгийн СУГ, соёлын төвийг баримтжуулах тоног төхөөрөмжөөр хангах.
6. Өвлөн уламжлагч нар амьдралын боломж муу, амьдралын шаардлагаар өөр зүйл хийж, мэдлэг, уламжлалаа залуучууддаа өвлүүлэх, түгээн таниулах тал дээр цалгардах, нөгөө талаараа тэднийг үнэлэх нийгмийн үнэлэмж доогуур буйг судалгааны үр дүн харуулж байна. Тиймээс холбогдох яамтай хамтарч СББӨ-ийн чиглэлд нэн тэргүүнд төсөл хөтөлбөрт оролцуулж, шалгаруулдаг байх Үүнд:
 - сум орон нутаг, сум хөгжүүлэх сангаас хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрт өвлөн уламжлагч нарыг эхний ээлжид хамруулдаг байх,
 - тайланг зөв зохистой гаргаж, зөв сурталчлах,
 - сумын засаг дарга нарын мөрийн хөтөлбөрт тусгуулдаг байх,
 - өвлөгчдийн өвлөж буй бүтээл, өв уламжлалд орж буй өөрчлөлтийн талаар хэлэлцүүлэг хийх, соёлын бүтээлч үйлдвэрлэл, өрхийн үйлдвэрлэл ялгаа заагийг тодруулах.

7. Гар урлалын ай савд хамаарах өвлөн уламжлагч, хамт олон бүлэг хүмүүс олон байна. Эдгээр өвлөн уламжлагчдад өрхийн орлогоо нэмэгдүүлэх, бүтээгдэхүүнээ эргэлтэд оруулах санхүүгийн эх үүсвэртэй болох төрийн дэмжлэг үгүйлэгдэж байна. Гар урлал, тэр дундаа дарханы урлал нь өөрөө өртөг зардал өндөртэй СББӨ-ийн төрөл тул зах зээл маркетинг менежментийн тодорхой мэдлэг олгохгүй бол өвлөн уламжлагч нар маань өрсөлдөх чадвар сул байна. Ингэхдээ аль өвийн зүйлийг бүтээлч үйлдвэрлэл (craft)-ийн хүрээнд, аль өвийг нь тансаг хэрэглээ (handcraft) урсгалаар нь хөгжүүлж тогтвортой хөгжих нөхцөлийг нь хангах төрийн бодлого, хөтөлбөр бий болгох.
8. СББӨ-ийн чиглэлээр аймгийн шинж чанартай үр ашигтай төсөл хөтөлбөрийг байгалийн нөөц баялаг, хүмүүсийн чадавх, сумдын онцлогт нийцүүлэн системтэй хэрэгжүүлэх.
9. Угсаатны бүлэгт тулгуурласан соёлын наадмуудыг эрчимжүүлэх .
10. Ерөнхий боловсролын сургуулийн цахим хичээлийн платформд соёлын өвийн талаарх мэдлэг, ойлголт олгох хичээл хязгаарлагдмал (1-2 сэдвийн хүрээнд) цөөн байгааг мэргэжлийн сургагч, судлаачид онцолж үүнийг бага, дунд, ахлах ангид тэнцвэртэйгээр хөтөлбөр боловсруулж, түгээн сурталчлах.
11. Хөгжлийн бэрхшээлтэй өвлөн уламжлагч нарын тусгай хэрэгцээ, давхар хамгааллыг харгалзан үзэх.
12. Улс, үндэсний хэмжээнд шавь сургалтын үр дүнг илүү онцлох, олон нийтэд сурталчлах, багш-шавь гэдэг уламжлалыг сурталчлах арга хэмжээг зохион байгуулах, шилдэг өвлөн уламжлагчдыг алдаршуулах, тэдэнд илүү боломж нөхцөлийг олгож, дэмжлэг үзүүлэх.
13. Өвлөн уламжлагч нарын ур чадварын түвшинг тогтоох, түвшинд үндэслэн шавь сургалт явуулах эрх олгох, улсын бүртгэлд бүртгэгдсэн зарим өвлөн уламжлагчдыг эргэж харах, чанаржуулах талаар арга хэмжээ авах хэрэгтэй.

Санал:

1. Нийслэлийн бүсийн СББӨ-ийн үзлэг судалгаанд нийслэлийн дүүргүүд “Соёлын биет бус үзлэг, бүсчилсэн судалгаа”-ны талаарх өвлөн уламжлагчдад мэдээлэл хүргэх, цуглуулах, ажлыг хангалтгүй зохион байгуулсныг дурдах нь зүйтэй. Салбарын шат шатны байгууллагууд “Соёлын биет бус өвийн үзлэг, бүсчилсэн судалгаа” -ны ажилд дүн шинжилгээ хийж үзлэгийн мөрөөр арга хэмжээг авч тайлагнадаг байх.
2. Аймаг, нийслэлийн СУГ-ын ажилтан (музейн БМСанч) ажлаас гарах, дэвших зэргээр солигдож байгаатай холбоотой бүртгэл мэдээллийн сангийн хадгалалтын аюулгүй байдал алдагдсан байна. (БМСангийн мэдээлэл устаж алга болох тохиолдол гарсаар байна.) Иймд БМСангийн хадгалалтын аюулгүй байдал хяналт тавьдаг байх.
3. Бүсийн үзлэг судалгааны багт хамрагдаж буй зураглаач нарт СББӨ-ийн баримтжуулалтын зарчим, жишиг стандартын талаар арга зүйгээр хангах.
4. СББӨ-ийн Улсын үзлэгийн багуудад тооллогод шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах.
5. Засгийн газрын 2018 оны 354 дүгээр тогтоолын хавсралт “Соёлын биет бус өвийг сурталчлан алдаршуулах, түгээн дэлгэрүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан өвлөн уламжлагчид мөнгөн шагнал олгох журам”-аар нэг жилд 1 хүнд олгодог 30 сая төгрөгийн урамшууллыг нэг жилд 2-3 хүнд хуваан олгож байхаар журамд оруулах саналыг судалгаанд хамрагдсан цөөн тооны өвлөн уламжлагчид үзлэгийн багаар дамжуулан уламжилсан.
6. СББӨ-ийн улсын анхдугаар үзлэг тооллого, баримтжуулалт судалгаа хийсэн цаг үеийн нөхцөл байдлаас хамааран зарим СББӨ-ийг үйлдэх цаг хугацаа нь өнгөрсөн учир

баримтжуулах нөхцөл бүрдээгүй зэрэг өв үйлдэгддэг цаг хугацаа, цаг агаар зэргийг бодолцох зайлшгүй шаардлагатай.

7. Судалгааны асуумж нь хэт олон асуулгатай байгаа нь өвлөн уламжлагч, оролцогчийг залхаахад хүргэсэн тул судалгааны асуумжийн тоо цөөн, оролцогчдод хялбараар боловсруулахад анхаарах хэрэгтэй гэж үзэв.